



МОНГОЛ УЛСЫН ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

ИДЛЭГ ШОНХОР ШУВУУ БАРИХ, ГАДААД ОРОНД ГАРГАХ ҮЙЛ АЖИЛЛАГААГ ЗОХИЦУУЛЖ БУЙ ХУУЛЬ ТОГТООМЖИЙН ХЭРЭГЖИЛТЭД ХИЙСЭН НИЙЦЛИЙН АУДИТЫН ТАЙЛАН



**ХУУЛЬ ТОГТООМЖИЙГ ХОЛБОГДОХ БАЙГУУЛЛАГА,
АЛБАН ТУШААЛТНУУД БҮРЭН ХЭРЭГЖҮҮЛЭЭГҮЙ БАЙНА**

Улаанбаатар хот
2017 он

Тайланг бэлтгэсэн:	Агуулга	2
Үндэсний аудитын газрын Нийцлийн аудитын газар	Товчилсон үгийн жагсаалт.....	3
Газрын захирал бөгөөд тэргүүлэх аудитор	Зураг болон хүснэгтэн мэдээллийн жагсаалт	3
Б.Алтанзул	Аудит хийх үндэслэл, зорилт, хамарсан хүрээ, хугацаа, арга зүй, аудитын явцад гарсан хүндрэл бэрхшээл	4
Аудитын менежер	Аудитад ашигласан шалгуур үзүүлэлт	5
Х.Болдбаатар	Үндсэн мэдээлэл.....	6-7
Аудитор	БҮЛЭГ 1. ИДЛЭГ ШОНХОР ШУВУУ БАРИХ, ГАДААД ОРОНД ГАРГАХ ҮЙЛ АЖИЛЛАГААГ ЗОХИЦУУЛЖ БУЙ ХУУЛЬ ТОГТООМЖИЙН ХЭРЭГЖИЛТ ХАНГАЛТГҮЙ БАЙНА	8-12
Ц.Гэрэл С.Сугармаа	1.1. Идлэг шонхор шувууг зохистой ашиглах талаар гарсан Засгийн газрын 2013-2014 оны шийдвэр нь шувууны нөөц, нөхөн сэргэх чадварт сөргөөр нөлөөлөхөөргүй байна	8-9
	1.2. Идлэг шонхор шувуу ашигласны болон өгөөшийн төлбөр, хураамжийг орон нутгийн төсөвт дутуу төвлөрүүлсэн байна.....	9-12
2017 оны 10 дугаар сар	БҮЛЭГ 2. ИДЛЭГ ШОНХОР ШУВУУ БАРИХ, ГАДААД ОРОНД ГАРГАХ ҮЙЛ АЖИЛЛАГААНД ТАВИХ ХЯНАЛТ СУЛ БАЙНА	13-17
	2.1. БОНХЯ (хуучнаар) идлэг шонхор шувуу барих, гадаад оронд гаргах үйл ажиллагаанд тавих хяналтын чиг үүргээ бүрэн хэрэгжүүлээгүй байна	13-15
	2.2. Идлэг шонхор шувуу барих үйл ажиллагаанд нутгийн захиргааны байгууллагаас тавих хяналт сул байна.....	16-17
	Холбогдох байгууллагаас ирүүлсэн санал.....	18-19
	Саналд өгөх тайлбар.....	20
	Дүгнэлт	21
	Зөвлөмж	22
	Хавсралт	23-27
	Монгол Улсын Ерөнхий аудиторовын тушаал.....	28
Уг тайланг ҮАГ-ын Вэб сайтаас үзнэ үү. www.audit.mn		
Аудитын тайлан дүгнэлттэй холбоотой асуудлаар нэмж тодруулах, асууж лавлах зүйл байвал 261729, 260949 дугаарын утас, факсаар харилцана уу.		
Хаяг: Үндэсний аудитын газар Засгийн газрын IV байр Бага тойруу-3, Чингэлтэй дүүрэг, Улаанбаатар хот 15160 Монгол Улс		

ТОВЧИЛСОН ҮГИЙН ЖАГСААЛТ

АНЭУ	Арабын Нэгдсэн Эмират Улс
БОАЖГ	Байгаль орчин, аялал жуулчлалын газар
БОАЖЯ	Байгаль орчин, аялал жуулчлалын яам
БОГ	Байгаль орчны газар
БОНХЯ	Байгаль орчин, ногоон хөгжлийн яам
ГЕГ	Гаалийн ерөнхий газар
МХЕГ	Мэргэжлийн хяналтын ерөнхий газар
МХГ	Мэргэжлийн хяналтын газар
ТББ	Төрийн бус байгууллага
УИХ	Улсын Их Хурал
ЦЕГ	Цагдаагийн ерөнхий газар
ТЕГ	Тагнуулын ерөнхий газар
ШУА	Шинжлэх ухааны академи
CITES	Зэрлэг амьтан ба ургамлын аймгийн ховордсон зүйлийг олон улсын хэмжээнд худалдаалах тухай конвенц

ЗУРАГ БОЛОН ХҮСНЭГТЭН МЭДЭЭЛЛИЙН ЖАГСААЛТ

ЗУРАГ 1	Идлэг шонхор шувууны гадаад төрх
ЗУРАГ 2	Өндөр хүчдэлд цохиулсан идлэг шонхор шувуу
ХҮСНЭГТ 1	Идлэг шонхор шувуу барих тусгай зөвшөөрөл олгосон, байгалийн нөөц ашигласны төлбөр төлсөн болон Монгол Улсын хилээр гаргасан тоо толгойн байдал /2013-2014 он/
ХҮСНЭГТ 2	Идлэг шонхор шувуу барих тусгай зөвшөөрөл олгосон, барьсан, төлбөр төлсөн, гадаад оронд гаргасан мэдээлэл /2013-2014 он/
ХҮСНЭГТ 3	Идлэг шонхор шувуу барих тусгай зөвшөөрөл олгосон, барьсан байдал /2014 он/
ХҮСНЭГТ 4	Удирдан зохицуулах зөвлөлөөс олгосон идлэг шонхор шувуу улсын хилээр гаргах гэрчилгээнд тусгагдсан хүйсийн тэнцвэрт байдлын мэдээлэл /2014 он/
СХЕМ 1	Идлэг шонхор шувуу барих, гадаад оронд гаргах үйл ажиллагааны дэс дарааллыг харуулсан схем

Аудит хийх үндэслэл

Аудитыг “Монголын мэргэжлийн анчдын холбоо” ТББ-ын хүсэлт, Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан төлөвлөгөө, “Аудитын төлөвлөгөөнд өөрчлөлт оруулах тухай” Монгол Улсын Ерөнхий аудиторын 2017 оны 06 дугаар сарын 05-ны өдрийн А/103 дугаар тушаалыг үндэслэн Төрийн аудитын тухай хуулиар тодорхойлсон Үндэсний аудитын газрын бүрэн эрхийн хүрээнд гүйцэтгэв.

Аудитын зорилт

Идлэг шонхор шувуу барих, гадаад оронд гаргах үйл ажиллагааг зохицуулж буй хууль тогтоомжийн хэрэгжилтэд аудит хийж, гарсан зөрчлийг арилгах, цаашид үйл ажиллагааг сайжруулах зөвлөмж боловсруулан холбогдох байгууллага, албан тушаалтанд хүргүүлэх, үр дүнг олон нийтэд мэдээлэхэд аудитын зорилт чиглэгдэв.

Аудитын зорилтыг хангахын тулд дараах чиглэлээр аудитыг хийж гүйцэтгэлээ. Үүнд:

- Идлэг шонхор шувуу барих, гадаад оронд гаргах үйл ажиллагаанд хууль тогтоомжийг бүрэн хэрэгжүүлсэн эсэх
- Идлэг шонхор шувуу барих, гадаад оронд гаргах үйл ажиллагаанд хяналт үр нөлөөтэй хэрэгжүүлсэн эсэх

Аудитын хамарсан хүрээ, хугацаа

Аудитад БОАЖЯ, ГЕГ, МХЕГ, ШУА-ийн Ерөнхий болон сорилын биологийн хүрээлэн, Архангай, Баянхонгор, Дорноговь, Дундговь, Завхан, Өвөрхангай, Сүхбаатар, Төв, Хэнтий, Ховд аймгийн МХГ, БОАЖГ болон зарим сумын ЗДТГ-ын 2013-2014 оны баримт материалыг хамруулав.

Аудитын төлөвлөгөө идлэг шонхор шувуу тусгай зориулалтаар гадаад улсад гаргасан 2013-2016 оны үйл ажиллагааг хамрахаар батлагдсан боловч идлэг шонхор шувуу барих тоо хэмжээг тогтоосон Засгийн газрын 2015-2016 оны тогтоолууд нууцын зэрэглэлтэй гарсан тул холбогдох материалтай танилцах хүсэлтийг ТЕГ-т тавихад “хуульд заасан зохицуулалтын дагуу ил болгох хүртэл танилцуулах боломжгүй” гэсэн хариуг 2017 оны н/283 тоот албан бичгээр ирүүлсний дагуу Монгол Улсын Ерөнхий аудиторын 2017 оны 06 дугаар сарын 05-ны өдрийн А/103 дугаар тушаалаар аудитын хамрах хугацааг 2013-2014 оноор хязгаарласан болно.

Аудитын арга зүй

Аудитыг гүйцэтгэхдээ АДБОУ-ын 100, 400, 4000, 4100 дугаар стандартууд, Төрийн хяналт шалгалтын стандарт, Нийцлийн аудитын түр журмыг баримтлан шалгагдагч байгууллагаас авсан мэдээлэл, нотлох зүйлсийг нягтлан шалгах, холбогдох албан тушаалтантай ярилцлага хийх, лавлагаа, тайлбар авах, санхүүгийн болон Зэрлэг амьтан ба ургамлын аймгийн ховордсон зүйлийг олон улсын хэмжээнд худалдаалах тухай олон улсын конвенцийн хэрэгжилтийн тайлан, үйл ажиллагааны тайланг судлах, харьцуулах, дүн шинжилгээ хийх, түүвэрлэлт хийх зэрэг аудитын бусад горим, арга зүйг ашиглаж, аудитын дүн, дүгнэлт, зөвлөмж боловсруулсан болно.

Аудитын дүн, дүгнэлтэд дэмжлэг болох нотлох зүйлс, холбогдох мэдээ, судалгааг ажлын баримт материалд хавсаргав.

Аудитын явцад гарсан хүндрэл, бэрхшээл

БОНХЯ (хуучнаар)-ны холбогдох албан тушаалтнууд идлэг шонхор шувуу барих, гадаад оронд гаргах үйл ажиллагаатай холбоотой баримт материалыг Архивын тухай хууль болон Байгууллагын архивын ажлын үндсэн зааврын дагуу архивын нэгж болгоогүй, ЦЕГ-ын Эрүүгийн цагдаагийн газрын Эдийн засгийн гэмт хэрэгтэй тэмцэх хэлтэст зарим материал хураагдсан, тусгай зориулалтаар идлэг шонхор шувуу барих тоо хэмжээг тогтоосон Засгийн газрын 2015-2016 оны тогтоолууд нууцын зэрэглэлтэй гарсантай холбогдуулан ТЕГ-аас холбогдох материалтай танилцуулаагүй нь уг үйл ажиллагааг бүрэн хэмжээгээр шалгаж, дүгнэлт гаргах боломжийг бууруулсан болно.

Аудитад ашигласан шалгуур үзүүлэлт

- Төрийн аудитын тухай хууль;
- Төсвийн тухай хууль;
- Татварын ерөнхий хууль;
- Байгаль орчныг хамгаалах тухай хууль;
- Амьтны тухай хууль;
- Байгалийн нөөц ашигласны төлбөрийн тухай хууль;
- Ховордсон амьтан, ургамал, тэдгээрийн гаралтай эд зүйлийн гадаад худалдааг зохицуулах тухай хууль;
- Улсын тэмдэгтийн хураамжийн тухай хууль;
- Зэрлэг амьтан ба ургамлын аймгийн ховордсон зүйлийг олон улсын хэмжээнд худалдаалах тухай олон улсын конвенц;
- “Нэн ховор, ховор амьтдыг хамгаалах үндэсний хөтөлбөр батлах тухай” Засгийн газрын 2011 оны 277 дугаар тогтоол;
- “Үнэлгээ, төлбөр, хураамжийн хэмжээг шинэчлэн батлах тухай” Засгийн газрын 2011 оны 23 дугаар тогтоол;
- “Тусгай зориулалтаар 2010 онд агнах, барих агнуурын амьтны тоо хэмжээг тогтоох тухай” Засгийн газрын 2009 оны 112 дугаар тогтоол;
- “Гадаадад гаргахыг хориглох тухай” Засгийн газрын 2013 оны 15 дугаар тогтоол;
- “2013 онд агнах, барих агнуурын амьтны тоо хэмжээг тогтоох тухай” Засгийн газрын 2013 оны 92 дугаар тогтоол;
- “Тогтоолд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай” Засгийн газрын 2013 оны 297 дугаар тогтоол;
- “2014 онд агнах, барих агнуурын амьтны тоо хэмжээг тогтоох тухай” Засгийн газрын 2014 оны 122 дугаар тогтоол;
- Холбогдох бусад хууль, дүрэм, журам

ҮНДСЭН МЭДЭЭЛЭЛ

Монгол Улсын Засгийн газрын 2012 оны 101 дүгээр тогтоолоор шонхор шувууг Монголын ард түмний эрч хүч, эрх чөлөө, эв нэгдэл, байгаль дэлхийгээ хайрлах үзлийн бэлэгдэл болгон “Үндэсний бахархалт шувуу”-гаар зарлаж, Засгийн газрын 2013 оны 15 дугаар тогтоолоор “Идлэг шонхорыг ашиг олох зорилгоор гадаад оронд гаргахыг 5 жилийн хугацаатай хориглох” тухай шийдвэр гаргасан байна.

Монгол Улсаас гадаад оронд амьдаар нь гаргах идлэг шонхор шувууны тоо хэмжээг Монгол Улсын Засгийн газрын тогтоолоор 2010-2011 онд жил бүр 240 толгой, 2012 онд 150 толгой байхаар тогтоож байсан бол дээрх шийдвэрийн дүнд ашиг олох зорилгоор гадаад улсад гаргах явдлыг зогсоож, 2013 онд 20 хүртэл толгой, 2014 онд 40 хүртэл толгой идлэг шонхор шувууг Амьтны тухай хуулийн 26 дугаар зүйлийн 26.3¹-т заасныг үндэслэн тусгай зориулалтаар гаргахаар шийдвэрлэжээ.


БОНХЯ (хуучнаар)-наас 2013-2014 онд Арабын Нэгдсэн Эмират Улс, Катар Улс, Кувейт Улсын дээд хэмжээний төлөөлөгчидтэй Монгол Улсаас идлэг шонхор шувуу бариулах, гадаад улсад гаргах талаар гэрээ байгуулан, 55 толгой шонхор шувуу барих тусгай зөвшөөрөл олгосон байна.

Уг шийдвэрийн хүрээнд “Зэрлэг амьтан ба ургамлын аймгийн ховордсон зүйлийг олон улсын хэмжээнд худалдаалах тухай” конвенци, Ховор амьтан, ургамал, тэдгээрийн гаралтай эд зүйлийн гадаад худалдааг зохицуулах тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.12² дахь заалтын дагуу Удирдан зохицуулах зөвлөлөөс 2013-2014 онд Кувейт Улс руу 35 толгой, Арабын Нэгдсэн Эмират улс руу 10 толгой, Катар Улс руу 10 толгой, нийт 55 толгой идлэг шонхор шувуу гаргах гэрчилгээг олгосноор Монгол Улсын хилээр дээрх тоо хэмжээний идлэг шонхор шувууг гаргасан байна.

¹ Тухайн жилд тусгай зориулалтаар агнах, барих агнуурын амьтны тоо хэмжээг төрийн захиргааны төв байгууллагын саналыг үндэслэн Засгийн газар тогтооно.

² Удирдан зохицуулах зөвлөл уг хүсэлтийг хүлээн авч, зөвшөөрөл, гэрчилгээ олгох асуудлыг шийдвэрлэнэ.

Идлэг шонхор шувуу барих, гадаад оронд гаргах үйл ажиллагааг схемээр харуулбал:



БҮЛЭГ 1

ИДЛЭГ ШОНХОР ШУВУУ БАРИХ, ГАДААД ОРОНД ГАРГАХ ҮЙЛ АЖИЛЛАГААГ ЗОХИЦУУЛЖ БУЙ ХУУЛЬ ТОГТООМЖИЙН ХЭРЭГЖИЛТ ХАНГАЛТГҮЙ БАЙНА

1.1. Идлэг шонхор шувууг зохистой ашиглах талаар гарсан Засгийн газрын 2013-2014 оны шийдвэр нь шувууны нөөц, нөхөн сэргэх чадварт сөргөөр нөлөөлөхөөргүй байна

Идлэг шонхор шувуу тусгай зориулалтаар гадаад улсад гаргах үйл ажиллагаа Байгаль орчныг хамгаалах тухай хууль, Амьтны тухай хууль, Ховор амьтан, ургамал, тэдгээрийн гаралтай эд зүйлийн гадаад худалдааг зохицуулах тухай хууль, Байгалийн нөөц ашигласны төлбөрийн тухай хууль, БОАЖ-ын сайдын 2012 оны А-299 дүгээр тушаалаар баталсан “Монгол Улсын нутаг дэвсгэр дээр идлэг шонхор амьдаар барих, тээвэрлэх, арчлах, экспортонд гаргах үйл ажиллагаанд мөрдөх журам” болон холбогдох бусад хууль, эрх зүйн актаар зохицуулагдаж байна.

Зураг №1



“Зэрлэг амьтан ба ургамлын ховордсон зүйлийг олон улсын хэмжээнд худалдаалах тухай конвенц”-д Монгол Улс 1995 онд нэгдэн орж, бүртгэгдсэн амьтан, ургамлыг устахаас сэргийлэх үүргийг хүлээсэн бөгөөд тус конвенцийн 2 дугаар хавсралтын устаж үгүй болох аюулд ороогүй ч гадаад худалдааг хатуу хяналт зохицуулалттайгаар явуулахгүй бол устах аюулд орж болзошгүй амьтны зүйлд идлэг шонхор шувуу бүртгэгдсэн байна.

Дээрх конвенцийн Амьтны хорооны 2006 оны 21 дүгээр хурлаас Монгол Улсыг идлэг шонхор шувуу экспортлохыг түдгэлзүүлэх шаардлагатай талаар зөвлөмж өгч байсан ч конвенцийн Байнгын хорооны 2011 оны 61 дүгээр хуралдаанаар идлэг шонхор шувууны тоо толгойн судалгааны үр дүнг харгалзан жилд 300 хүртэл толгой идлэг шонхор экспортолж байхыг зөвлөж,

шийдвэрлэсэн байна³.

Конвенцийг хэрэгжүүлэхтэй холбоотой харилцааг зохицуулах зорилгоор УИХ-аас 2002 онд баталсан Ховордсон амьтан, ургамал, тэдгээрийн гаралтай эд зүйлийн гадаад худалдааг зохицуулах тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.3⁴-т идлэг шонхор шувууг ашиг олох зорилгоор худалдаалж болохыг хуульчилжээ.

Байгаль орчныг хамгаалах тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.2⁵-т заасны дагуу БОАЖЯ-ны захиалгаар Шинжлэх ухааны академийн Ерөнхий болон сорилын биологийн хүрээлэнгээс 2010 онд гүйцэтгэсэн идлэг шонхор шувууны тархац, нөөцийн үнэлгээ тогтоох судалгаагаар 6830 идлэг шонхорын нөөцийг тогтоосон байна.

Дээрх хугацаанаас хойш идлэг шонхор шувууны биологийн нөөцийн судалгаа дахин хийгдээгүй бөгөөд 2010 онд төвийн болон зүүн бүсийн 20 сумын нутагт байрлуулсан 5000 ширхэг хиймэл үүрэнд 2014 онд 766 хос үүрлэж, 2323 ангаахай амжилттай бойжсон байна.⁶

Байгаль орчныг хамгаалах тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 24.1⁷, 24.2⁸-т заасны дагуу Монгол Улсын Засгийн газраас “2013 онд агнах, барих агнуурын амьтны тоо хэмжээг тогтоох тухай” 92 дугаар тогтоолоор 20 хүртэл толгой, “2014 онд агнах, барих агнуурын амьтны тоо хэмжээг тогтоох тухай” 122 дугаар тогтоолоор 40 хүртэл толгой идлэг шонхор шувууг тусгай зориулалтаар барихаар тогтоосон байна.

³ БОНХЯ. Зэрлэг амьтан ба ургамлын аймгийн ховордсон зүйлийг олон улсын хэмжээнд худалдаалах тухай конвенцийн Үндэсний анхдугаар тайлан. УБ., 2014 он, 34 дэх тал

⁴ конвенцийн 2, 3 дугаар хавсралтад орсон амьтан, ургамал, тэдгээрийн гаралтай эд зүйлийг ашиг олох зорилгоор худалдаалж болно.

⁵ Төрийн захиргааны төв байгууллага нь эрдэм шинжилгээний болон мэргэжлийн байгууллагад байгаль орчны судалгаа, шинжилгээний ажил хийх, төсөл боловсруулах захиалга өгч, зохих төсвийн хөрөнгөөр санхүүжүүлэх, дэмжлэг үзүүлнэ.

⁶ БОНХАЖЯ. Байгаль орчны төлөв байдлын тайлан. 2013-2014 он, 91 дэх тал.

⁷ Байгалийн баялгийн нөөцийг түүний даац, нөхөн сэргэх чадварыг харгалзан тодорхой хугацаанд ашиглаж болох хэмжээг байгалийн баялгийн нөөцийн ашиглалтын дээд хэмжээ гэнэ

⁸ Байгалийн баялгийн нөөцийн ашиглалтын дээд хэмжээг байгалийн тухайн баялгийг хамгаалах, зохистой ашиглах тухай хуульд заасны дагуу тогтооно.

Идлэг шонхор шувуу тусгай зориулалтаар барих тоо хэмжээг тогтоосон Монгол Улсын Засгийн газрын дээрх шийдвэрүүд нь “Зэрлэг амьтан ба ургамлын аймгийн ховордсон зүйлийг олон улсын хэмжээнд худалдаалах тухай конвенц”-ийн Байнгын хорооны зөвлөмжид заасан тоо хэмжээ болон шувууны нөөц, нөхөн сэргэх чадварт сөргөөр нөлөөлөхөөргүй байх хуулийн заалттай нийцсэн байна.

1.2. Идлэг шонхор шувуу ашигласны болон өгөөшийн төлбөр, хураамжийг орон нутгийн төсөвт дутуу төвлөрүүлсэн байна

Идлэг шонхор шувуу барих тусгай зөвшөөрөл олгосон, байгалийн нөөц ашигласны төлбөр төлсөн болон Монгол Улсын хилээр гаргасан тоо толгойн байдлыг 2013-2014 оноор үзүүлбэл:

Хүснэгт №1

Улсын нэр	2013 он			2014 он			Нийт		
	Зөвшөөрөл олгосон	Төлбөр төлсөн	МУ-ын хилээр гарсан	Зөвшөөрөл олгосон	Төлбөр төлсөн	МУ-ын хилээр гарсан	МУ-ын хилээр гарсан	Төлбөр төлсөн	Төлбөр төлөөгүй
АНЭУ	-	-	-	10	5	10	10	5	5
Катар	-	-	-	10	10	10	10	10	0
Кувейт	15	13	15	20	18	20	35	33	4
Дүн	15	13	15	40	33	40	55	46	9

Хүснэгтээс үзвэл нийт 60 хүртэл толгой идлэг шонхор шувуу барьж, гадаад оронд гаргах тухай Засгийн газрын шийдвэр гарснаас улсын хилээр нийт 55 толгой идлэг шонхор шувуу гаргасан байна.

Амьтны тухай хууль, Байгалийн нөөц ашигласны төлбөрийн тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.1.2-т заасныг баримтлан орон нутгийн төсөвт гадаад оронд гаргасан 46 шувууны байгалийн нөөц ашигласны төлбөрт 279.3 сая төгрөгийг төвлөрүүлсэн байна.

Арабын Нэгдсэн Эмират Улсад гаргасан 5, Кувейт Улсад гаргасан 4, нийт 9 толгой шувуунд ногдох төлбөрийг төвлөрүүлээгүй байна.

Байгалийн нөөц ашигласны төлбөрийн тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.1.6-т “гадаадын иргэнд агнуулсан болон гадаад улсад амьдаар нь аливаа зориулалтаар гаргасан ан амьтны төлбөрийг тухайн ан олзворын гадаад зах зээлийн тухайн үеийн үнэ буюу эрх бүхий байгууллагаас тогтоосон жишиг үнээр тооцно” гэж заажээ.

Мөн хуулийн 17 дугаар зүйлийн 17.1.2-т “ахуйн, үйлдвэрлэл, соёл, шинжлэх ухааны зориулалтаар агнасан бусад ан амьтны төлбөрийг тухайн ан амьтны толгой тутмын экологи-эдийн засгийн үнэлгээний 20-40 хувиар”, 17.1.6-т “амьдаар нь гадаад оронд гаргасан ан амьтны төлбөрийг гадаад зах зээлийн тухайн үеийн үнэ буюу эрх бүхий байгууллагаас тогтоосон жишиг үнийн 80-90 хувиар тооцох”-оор тус тус зааж, ан амьтны нөөцийг гадаад улсад гаргах тохиолдолд нөөц ашигласны төлбөр өндөр дүнтэй байхаар хуульчилсан байна.

Эрх зүйн энэ зохицуулалтаас үзэхэд аливаа зориулалтаар гадаад оронд гаргаж буй идлэг шонхор шувууны байгалийн нөөц ашигласны төлбөрийг эрх бүхий байгууллагаас тогтоосон жишиг үнээс тооцохоор байна.

Идлэг шонхор шувуу амьдаар нь гадаад оронд гаргахдаа Байгалийн нөөц ашигласны төлбөрийн тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.1.6 дахь заалт, Засгийн газрын 2009 оны 112 дугаар тогтоолоор тогтоосон төлбөр 10.8 мян ам.доллар /12.0 мян ам.доллараас 90 хувиар тооцсон/-оор тооцож, орон нутгийн төсөвт төвлөрүүлэхээр заасан байна.

Гэтэл БОАЖ-ын сайдын 2012 оны А-299 дүгээр тушаалаар баталсан “Монгол Улсын нутаг дэвсгэр дээр идлэг шонхор амьдаар барих, тээвэрлэх, арчлах, экспортонд гаргах үйл ажиллагаанд мөрдөх журам”-д гадаад оронд худалдаалах зорилгоор идлэг шонхор шувуу барихад Засгийн газрын 2009 оны 112 дугаар тогтоолоор баталсан төлбөр хураамж /төлбөр 10.8 мянган ам.дол, хураамж 960 ам.дол/-ыг мөрдөхөөр, харин судалгаа шинжилгээ болон бусад зорилгоор барихад Засгийн газрын 2011 оны 23 дугаар тогтоолоор баталсан экологи-эдийн засгийн үнэлгээ /16.0 сая

төгрөг/-г баримтлахаар тус тус зааж, хоёр өөр төлбөр тогтоосон нь хуулийн дээрх заалтыг зөрчсөн байна.

БОНХЯ(хуучнаар)-ны Хүрээлэн буй орчин, байгалийн нөөцийн газраас (хуучнаар) идлэг шонхор шувуу барих тусгай зөвшөөрлийг гадаадын иргэдэд олгохдоо хуулийн заалтыг буруу хэрэглэж Засгийн газрын 2011 оны 23 дугаар тогтоолоор тогтоосон экологи-эдийн засгийн үнэлгээ болох 16.0 сая төгрөгийн 40.0 хувиар тооцон 6.4 сая төгрөгийг төлүүлж, төсвийн орлого дутуу төвлөрөх нөхцөлийг бүрдүүлсэн байна.

Идлэг шонхор шувуу барих тусгай зөвшөөрөл олгосон, барьсан, төлбөр төлсөн, гадаад оронд гаргасан мэдээллийг 2013-2014 оноор үзүүлбэл:

Хүснэгт №2

Тусгай зориулалтаар барих зөвшөөрөл олгосон				Байгалийн нөөц ашигласны төлбөр			Экспорт-лосон
Улсын нэр: гэрээ	Тусгай зөвшөөрлийн дугаар	тоо	Аймаг	тоо	Сумдын нэр	Төлбөр /сая төг/	Тоо
2013 он							
Кувейт - 2013 онд 20 хүртэл толгой. 2013.08.27	6/4555,	10	Төв, Хэнтий, Дундговь, Сүхбаатар, Дорноговь	10	Хэнтий -10 сум	52.9	15
		5		3	Сүхбаатар Уулбаян	15.2	
2013 он дүн		15		13		68.1	15
2014 он							
Кувейт-2014 онд 20 хүртэл толгой 2014.07.02	00000 52	3	Архангай	2	Хотонт	12.8	20
	0000 128	2	Баянхонгор	2	Баянбулаг	12.8	
	00000 54	3	Завхан	1	Түдэвтэй	6.4	
	00000 53	3	Өвөрхангай	1	Өлзийт	6.4	
	00000 50	3	Сүхбаатар	2	Есөнзүйл	12.8	
	00000 46	8	Хэнтий Дундговь	0	-	0	
Дүн		22		18		115.2	20
АНЭУ- бэлэг МУЗГ-ын 2014 оны ЗГ-1/146 албан бичиг	00000 89	1	Завхан	2	Түдэвтэй	12.8	10
	00000 91	3	Өвөрхангай	0	-	-	
	00000 87	2	Сүхбаатар	0	-	-	
	00000 86	2	Хэнтий	1	Мөрөн	6.4	
	00000 90	1	Ховд	0	-	-	
	00000 88	1	Төв	0	-	-	
	Зөвшөөрөлгүй барьсан		Баянхонгор	1	Баянбулаг	6.4	
				1	Заг сум	6.4	
Дүн		10		5		32.0	
Катар Улс	00000 75	2	Архангай	0	-	0	10
	00000 78	1	Дундговь	0	-	0	
	00000 74	2	Завхан	0	-	0	
	00000 76	1	Өвөрхангай	2	Есөнзүйл	12.8	
	00000 73	1	Сүхбаатар	2	Халзан	12.8	
				2	Онгон	12.8	
				2	Уул баян	12.8	
	00000 72	2	Хэнтий	1	Дэлгэрхаан	6.4	
	00000 77	1	Төв	1	Мөрөн	6.4	
Дүн		10		10		64.0	
Тусгай зөвшөөрөлд улсын нэр заагаагүй	0000 108	5	Хэнтий ,Төв, Дорноговь, Дорнод	0	-	0	0
2014 оны дүн		47		33		211.2	40
Нийт /2013- 2014 он/		60		46		279.3	55

Аудитад хамрагдсан хугацаа болох 2013 онд 15 шувууны /15 шувуу *1659.34⁹ төг*11760 ам.дол/ төлбөр, хураамжид 292.7 сая төгрөг, 2014 онд 40 шувууны /40 шувуу*11760 ам.дол*1888.44¹⁰ төг/ 888.3 сая төгрөг, нийт 1,181.0 сая төгрөг орон нутгийн төсөвт төвлөрүүлэхээс 279.3 сая төгрөгийг төвлөрүүлж, 901.7 сая төгрөгийг дутуу төвлөрүүлсэн байна.

Аймаг дахь Төрийн аудитын газруудаас ирүүлсэн судалгаагаар 2014 онд Хэнтий аймгийн Мөрөн суманд Катар Улсын анчдаас өгөөш болох 300 тагтааны үнэнд 512.0 мянган төгрөг төлснийг эс тооцвол бусад идлэг шонхор шувуу барихад ашиглаж буй өгөөшийн төлбөрийг төлөөгүй байна.

“Монгол Улсын нутаг дэвсгэр дээр идлэг шонхор амьдаар барих, тээвэрлэх, арчлах, экспортонд гаргах үйл ажиллагаанд мөрдөх журам”-ын 8 дугаар зүйлийн 8.3-т “нэг толгой идлэг шонхор барихад өгөөш болгон ашиглах тагтаа, ногтрууны тоо 10-аас илүүгүй байна” гэж заасан байна.

Эндээс үзвэл 2013 онд 150 өгөөшийн төлбөр хураамжид /15 шувуу*10 өгөөш *12 ам.дол*1659.34 төг/ 2.9 сая төгрөг, 2014 онд 400 өгөөшийн төлбөр хураамжид /40 шувуу*10 өгөөш *12 ам.дол*1888.44 төг/ 9.1 сая төгрөг, нийт 12.0 сая төгрөг орон нутгийн төсөвт төвлөрөхөөс 0.5 сая төгрөг төвлөрч, 11.5 сая төгрөг дутуу төвлөрсөн байна.

Нийт идлэг шонхор шувууны байгалийн нөөц ашигласны төлбөр, хураамж болон өгөөш болгон ашигласан тагтаа ногторууны төлбөр, хураамжид нийт 913.2 сая төгрөгийг орон нутгийн төсөвт дутуу төвлөрүүлж Амьтны тухай хуулийн 32.1¹¹, Засгийн газрын 2011 оны 65 дугаар тогтоолд ой хээрийн бусад агнуурын шувуу шувууны төлбөр хураамжид 12 ам.доллар төлнө гэж заасныг тус тус зөрчсөн байна.

Төсвийн тухай хуулийн 23 дугаар зүйлийн 23.8¹², Байгалийн нөөц ашигласны төлбөрийн тухай хуулийн 23 дугаар зүйлийн 23.1-23.2¹³-т заасны дагуу төлбөр хураамжийг орон нутгийн төсөвт төлөх хуулийн зохицуулалттай байхад “Монгол Улсын нутаг дэвсгэр дээр идлэг шонхор амьдаар барих, тээвэрлэх, арчлах, экспортонд гаргах үйл ажиллагаанд мөрдөх журам”-аар төлбөр, хураамжийг БОАЖЯ-ны холбогдох дансанд төвлөрүүлэхээр журамласан нь дээрх хуулийн заалттай нийцэхгүй байна. Дээрх асуудлаар БОАЖЯ-д албан шаардлага хүргүүлээ.

Амьтны тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1-д “Тусгай төлбөр төлсөн иргэнд энэ хуулийн 24.3.3-т заасан зориулалтаар агнах, барих тусгай зөвшөөрлийг төрийн захиргааны төв байгууллага олгоно” гэж заасан байхад БОНХЯ (хуучнаар)-ны Хүрээлэн буй орчин байгалийн нөөцийн газраас тусгай зөвшөөрлийг төлбөр төлөөгүй байхад олгосныг аудитын явцад тогтоосон болно.

Монгол Улсын Засгийн газрын 2009 оны 112 дугаар тогтоолын 2 дугаар зүйлд амьдаар барих идлэг шонхор шувууны хураамжийг ам.доллараар тогтоосныг Төлбөр тооцоог үндэсний мөнгөн тэмдэгтээр гүйцэтгэх тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.3¹⁴-т заасантай нийцүүлэн, шинэчлэн батлаагүй байна.

Сүүлийн жилүүдэд идлэг шонхор шувуу 15 кВт-ын цахилгаан дамжуулах агаарын шугамын шон дээр сууснаас өндөр хүчдэлд цохиулан үхэх тохиолдол ихэссэнийг судалгаагаар тогтоосон байна. Тухайлбал: Зэрлэг амьтан судлах, хамгаалах төв, Англи Улсын зэрлэг амьтны зөвлөх компани болох International Wildlife Center-ийн хийсэн судалгаагаар 2013 онд 27 шугам шалгаж 277 үхсэн махчин шувуу олж, цуглуулснаас 18 хувь буюу 50 нь идлэг шонхор, 2014 онд 26 шугам шалгаж 513 үхсэн махчин шувуу олж, цуглуулснаас 67 хувь буюу 342 нь идлэг шонхор байсан дүн гарчээ.

⁹ Монголбанкны цахим хуудас. 2013 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн ханш

¹⁰ Монголбанкны цахим хуудас. 2014 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн ханш

¹¹ Иргэн, хуулийн этгээд амьтан ашиглах, агнуурын амьтан агнах, барихад төлбөр, хураамж төлнө

¹² Сум, дүүргийн төсвийн татварын орлого дараах орлогоос бүрдэнэ:

23.8.4. агнуурын нөөц ашигласны төлбөр, ан амьтан агнах, барих зөвшөөрлийн хураамж;

¹³ **23 дугаар зүйл. Байгалийн нөөц ашигласны төлбөр төлөх**

23.1. Сум, дүүргийн Засаг дарга байгалийн нөөц ашигласны төлбөр хураах эрх бүхий албан тушаалтныг томилон ажиллуулна.

23.2. Байгалийн нөөц ашигласны төлбөрийн орлогыг дараа сарын 10-ны өдрийн дотор орон нутгийн төсөвт төлж, төлбөрийн жилийн тайланг дараа оны 01 дүгээр сарын 10-ны өдрийн дотор харьяалагдах татварын албанд тушааж эцсийн тооцоо хийнэ.

¹⁴ Монгол Улсын хууль тогтоомжид хураамж, шимтгэл, хариуцлагын хэмжээг тодорхойлохдоо зөвхөн төгрөгөөр илэрхийлнэ



Судалгааны дүнгээс үзвэл зүй бусын хорогдолд өртөж буй идлэг шонхор шувуудыг хамгаалах ажлын зардлыг байгалийн нөөц ашигласны төлбөрийн орлогоос санхүүжүүлэх шаардлага зайлшгүй гарч байна.

Агнуурын нөөц ашигласны төлбөр, ан амьтан агнах, барих зөвшөөрлийн хураамжийн тухай хууль /2012 онд хүчингүй болсон/-ийн 7 дугаар зүйлийн 7.3¹⁵-т заасны дагуу ангийн төлбөр, хураамжийн орлогыг Сангийн яамны Монголбанкн дахь валютын дансанд төвлөрүүлдэг байх үед 2006-2010 оны байдлаар шонхорын орлого 12.6 тэрбум¹⁶ төгрөг төсөвт төвлөрч байсан байна.

Байгалийн нөөц ашигласны төлбөрийн тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1, Засгийн газрын 2014 оны 43 дугаар тогтоолоор баталсан “Байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээнд зарцуулах төлбөрийн орлогын хэсгийг бүрдүүлэх, зарцуулах, тайлагнах журам”-д идлэг шонхор шувууны байгалийн нөөц ашигласны төлбөрийн орлогын 50-иас доошгүй хувийг тухайн шатны иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаар батлуулсны үндсэн дээр аймаг, нийслэл, сум, дүүргийн Засаг дарга нар дээрх шувууг хамгаалах арга хэмжээнд захиран зарцуулахаар заасан байна.

Гэвч уг орлогоос улсын төсөвт татан төвлөрүүлж, холбогдох төрийн захиргааны төв байгууллагууд идлэг шонхор хамгаалах нэгдсэн арга хэмжээнд зарцуулах боломж байхгүй байна.

Идлэг шонхор шувууны жишиг үнэ, төлбөр, хураамж, экологи-эдийн засгийн үнэлгээ тогтоосон Засгийн газрын 2009 оны 112, 2011 оны 23 дугаар тогтоолуудыг батлахад үндэслэл болгосон Ан агнуурын тухай хууль, Агнуурын нөөц ашигласны төлбөр, ан амьтан агнах, барих зөвшөөрлийн хураамжийн тухай хуулиуд нь 2012 онд Амьтны тухай хууль, Байгалийн нөөц ашигласны төлбөрийн тухай хуулиуд батлагдсанаар хүчингүй болсон байхад Засгийн газар төлбөр хураамжийн хэмжээг шинэчлэн батлаагүй байна.

Энэ нь Засгийн газрын 2010 оны 119 дүгээр тогтоолоор батлагдсан Захиргааны хэм хэмжээ тогтоосон шийдвэр гаргах журам /ЗГ-ын 2016 оны 86 дугаар тогтоолоор хүчингүй болсон/-ын 2.1.1-т “Хуулиар тусгайлан эрх олгогдсон эрх бүхий этгээд тухайн харилцааг зохицуулах хууль шинээр батлагдан гарсан, хууль хүчингүй болсон тохиолдолд нэн даруй шийдвэр гаргана”, Захиргааны ерөнхий хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.1-т заасан захиргааны хэм хэмжээний акт хуульд нийцсэн байх гэсэн заалтыг тус тус зөрчсөн байна.

Засгийн газрын 2009 оны 112, 2011 оны 23 дугаар тогтоолуудыг Амьтны тухай хууль болон Байгалийн нөөц ашигласны төлбөрийн тухай хуульд нийцүүлэн шинэчлэн батлах шаардлагатай байна.

Аудитын дүнгээр 2013-2014 оны хугацаанд гадаадад гаргасан 55 толгой идлэг шонхор шувууны төлбөр, хураамж 901.7 сая төгрөг, өгөөшийн төлбөрт 11.5 сая төгрөг, нийт 913.2 сая төгрөгийг орон нутгийн төсөвт дутуу төвлөрүүлсэн байна.

¹⁵ “...төлбөр, хураамжийг гадаадын иргэнд ан амьтан агнуулах болон ан амьтанг амьдаар гадаад оронд гаргах аж ахуйн нэгж, байгууллага байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад төлнө”.

¹⁶ Audit.mn/ҮАГ-ГАГ/2010/01-БОА “Монгол орны нэн ховор, ховор амьтдын хамгаалалтын байдал” аудитын тайлан. 10 дахь тал

БҮЛЭГ 2.

ИДЛЭГ ШОНХОР ШУВУУ БАРИХ, ГАДААД ОРОНД ГАРГАХ ҮЙЛ АЖИЛЛАГААНД ТАВИХ ХЯНАЛТ СУЛ БАЙНА

2.1. БОНХЯ (хуучнаар) идлэг шонхор шувуу барих, гадаад оронд гаргах үйл ажиллагаанд тавих хяналтын чиг үүргээ бүрэн хэрэгжүүлээгүй байна

Монгол Улсын Засгийн газраас баталж хэрэгжүүлсэн “Идлэг шонхор шувуу хамгаалах үндэсний хөтөлбөр”-ийн хэрэгжих хугацаа дуусч, Засгийн газрын 2011 оны 277 дугаар тогтоолоор “Нэн ховор, ховор амьтдыг хамгаалах үндэсний хөтөлбөр”-ийг 2011-2021 онд хэрэгжүүлэхээр баталсан байна.

Уг хөтөлбөрийн 3 дугаар зорилтын хүрээнд “идлэг шонхор шувуу хууль бусаар ашиглахыг зогсоох зорилгоор хамгаалалтыг сайжруулсны үндсэн дээр тогтвортой ашиглах нөхцөлийг бүрдүүлнэ”, “...экологи эдийн засгийн үнэлгээ баталгаажиж, идлэг шонхор зэрэг амьтдыг тусгай зориулалтаар ашиглах нөхцөл бүрдэнэ” гэж заасан боловч хөтөлбөрийн үе шатуудад ямар арга хэмжээ хэрэгжүүлэх нь тодорхойгүй байна.

Байгаль орчныг хамгаалах тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1.1¹⁷, 15.1.2¹⁸-т заасны дагуу БОНХЯ (хуучнаар) идлэг шонхор шувуу хамгаалах, зохистой ашиглах, учирч болох хохирлоос урьдчилан сэргийлэх, учирсан хохирлыг арилгуулах төрийн бодлого, хууль тогтоомжийг хэрэгжүүлэх, шийдвэр, дүрэм, журам баталж биелэлтийг хангуулах чиг үүргийг хэрэгжүүлэхээр байна.

Гэтэл Байгаль орчныг хамгаалах тухай хуулийн 35 дугаар зүйлийн 35.1.6¹⁹, Амьтны тухай хуулийн 31 дүгээр зүйлийн 31.1²⁰-д зааснаар идлэг шонхор шувууны тархац нутаг, нөөц, үнэлгээ, судалгааны тайлан, мэдээ баримт, тархац, нягтаршлыг аймаг, нийслэлээр харуулсан зургийг амьтны мэдээллийн санд бүртгэхээр хуульчилсан байхад мэдээллийн санг бүрдүүлээгүй байна.

Эндээс үзвэл Байгаль орчныг хамгаалах тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.15²¹, 38 дугаар зүйлийн 38.1²²-д заасан амьтны мэдээллийн санг бүрдүүлэх, улсын хэмжээнд удирдан зохион байгуулах, хяналт тавих чиг үүргээ БОНХЯ (хуучнаар) хангалтгүй хэрэгжүүлсэн байна.

Аудитын явцад идлэг шонхор шувуу барих тусгай зөвшөөрлийг олгохдоо амьтны мэдээллийн сан дахь идлэг шонхор шувууны тархац нутгийн мэдээллийг үндэслэн олгоогүйг тогтоосон бөгөөд энэ нь тусгай зөвшөөрөлд заасан аймгаас өөр газраас барих зөрчил гаргахад хүргэсэн байна.

¹⁷ байгаль орчныг хамгаалах, түүний баялгийг зохистой ашиглах, нөхөн сэргээх, байгаль орчны тэнцлийг хангах, байгаль орчинд учирч болох хохирлоос урьдчилан сэргийлэх, учирсан хохирлыг арилгуулах төрийн бодлого, хууль тогтоомжийг хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулах

¹⁸ байгаль орчныг хамгаалах нөхөн сэргээх, тогтвортой ашиглах, байгаль орчинд учруулсан хохирлыг нөхөн төлүүлэх тодорхой асуудлаар төрийн захиргааны төв байгууллага, аймаг, нийслэлийн хэмжээнд мөрдөх шийдвэр, дүрэм, журам батлаж биелэлтийг хангуулах

¹⁹ 35 дугаар зүйл.Мэдээллийн сангийн бүрдэл

1.Улсын мэдээллийн сан дараахь зүйлийн талаархи мэдээллээс бүрдэнэ:

6/амьтан;

²⁰ 31.1.Амьтны мэдээллийн сан дараахь мэдээллээс бүрдэнэ:

31.1.1.амьтны тархац нутаг, нөөц, түүний үнэлгээ;

31.1.2.амьтны судалгааны тайлан, мэдээ баримт;

31.1.3.амьтны цуглуулга, лабораторид хадгалсан үр хөврөл;

31.1.4.амьтан хамгаалах, өсгөн үржүүлэх, ашиглах арга хэмжээний мэдээ;

31.1.5.агнуурын амьтны тархац, нягтаршлыг аймаг, нийслэлээр харуулсан зураг.

²¹ байгаль орчны мэдээллийн сангийн үйл ажиллагааны талаархи хууль тогтоомжийг хэрэгжүүлэх ажлыг нэгдсэн удирдлагаар хангаж, хэрэгжилтэд нь хяналт тавих

²² Байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага мэдээллийн сангийн үйл ажиллагааг улсын хэмжээнд удирдан зохион байгуулна

Идлэг шонхор шувуу барих тусгай зөвшөөрөл олгосон, барьсан байдлыг орон нутгаар үзүүлбэл /2014 он/:

Хүснэгт №3

№	Аймаг	АНЭУ		Кувейт улс		Катар улс	
		Зөвшөөрөл олгосон	Барьсан	Зөвшөөрөл олгосон	Барьсан	Зөвшөөрөл олгосон	Төлбөр төлсөн
1	Архангай	-	-	3	2	2	-
2	Баянхонгор	-	2	2	2	-	-
3	Дорноговь	-	-	-	-	-	-
4	Завхан	1	2	3	1	2	-
5	Өвөрхангай	3	-	3	3	1	2
6	Сүхбаатар	2	-	3	-	1	6
7	Төв	1	-	-	-	1	-
8	Ховд	1	-	-	-	-	-
9	Хэнтий, Дундговь	2	1	8	10	3	2
	Дүн	10	5	22	18	10	10

Дээрх хүснэгтээс харахад Баянхонгор аймгаас идлэг шонхор шувуу барих зөвшөөрөл олгоогүй байхад 2 толгойг барьсан, Өвөрхангай, Сүхбаатар, Хэнтий, Дундговь аймгаас тусгай зөвшөөрөлд заасан тоо хэмжээнээс хэтрүүлэн барьсан зөрчил гарсан байна.

Харин БОАЖЯ 2013 онд Дундговь, Дорноговь, Сүхбаатар, Төв, Хэнтий аймгуудаас идлэг шонхор шувуу барих тусгай зөвшөөрөл олгосны дагуу Хэнтий аймгаас 10, Сүхбаатар аймгаас 3 толгой идлэг шонхор шувууг тус тус барьсан байна.

Амьтны тухай хуулийн 34 дүгээр зүйлийн 34.1²³, 34.2²⁴-т заасан идлэг шонхор шувуу агнах, барих, тавих, арчилж тордох, ачиж тээвэрлэхдээ эрүүл ахуй, осол аюулгүйн шаардлагыг хангасан арга технологи, багаж хэрэгсэл, байр сав, тохиромжтой цаг хугацаа, зориулалтын тоноглогсон тээврийн хэрэгсэл ашиглаж, мэргэшсэн хүмүүсийг ажиллуулах, агнуур хийх үйл ажиллагааг явуулахдаа амьтны жам ёсны эрхийг хүндэтгэн энэрэнгүй ёсоор хандах асуудлыг холбогдох журмаар нарийвчлан зохицуулаагүй байна.

“Монгол Улсын нутаг дэвсгэр дээр идлэг шонхор амьдаар барих, тээвэрлэх, арчлах, экспортод гаргах үйл ажиллагаанд мөрдөх журам”-аар идлэг шонхор барих гэрээ байгуулах, зөвшөөрөл олгох, гадаад оронд гаргах, хяналт тавихтай холбоотой харилцааг нарийвчлан зохицуулж байгаа бөгөөд уг журмын заалт зөрчигдсөн байна. Тухайлбал:

- 2013 онд Кувейт улсын төлөөлөгч Монгол Улсад айлчилж байгаатай холбогдуулан Гадаад Харилцааны сайдаас гаргасан хүсэлтийг харгалзан, мөн 2014 онд Монгол Улсын Засгийн газраас АНЭУ-ын төлөөлөгчид илгээсэн идлэг шонхор шувуу бэлэлзэх тухай албан бичгийг үндэслэн гэрээ байгуулахгүйгээр тусгай зөвшөөрөл олгосон нь журмын 2 дугаар зүйлийн 2.1²⁵-д заасныг зөрчсөн;
- БОАЖ-ын сайдын тушаалаар идлэг шонхор амьдаар нь барих, тээвэрлэх, арчлах, экспортод гаргах үйл ажиллагааг зохион байгуулах ажлын хэсэг байгуулж, хяналт тавихаар журамласан байхад ажлын хэсгийг байгуулаагүйгээс 7.1²⁶, 7.2²⁷ дахь заалт хэрэгжээгүй;
- Журмын 8 дугаар зүйлийн 8.1-д идлэг шонхор барих авто тээврийн хэрэгслийн тоо нь гэрээлэгч тус бүрийн 10 шонхор тутамд 5-аас илүүгүй байна, 8.2-т идлэг шонхор барих гадаадын иргэдийн тоо гэрээлэгч тус бүрийн 10 шонхор тутамд 8-аас илүүгүй байна гэж заасан байхад 10 толгой идлэг шонхор тутамд 14 гадаадын иргэн, 17 автомашин явсан байна.

БОНХЯ(хуучнаар)-ны дэргэд ажиллаж буй Удирдан зохицуулах зөвлөлөөс олгосон идлэг шонхор шувуу улсын хилээр гаргах гэрчилгээнд тусгагдсан хүйсийн тэнцвэрт байдлын 2014 оны мэдээллийг хүснэгтээр үзүүлбэл:

²³ Амьтныг өмчлөх, эзэмших, ашиглах, агнуур хийх үйл ажиллагааг явуулахдаа амьтны жам ёсны эрхийг хүндэтгэн энэрэнгүй ёсоор хандана.

²⁴ Амьтныг агнах, барих, тавих, арчилж тордох, ачиж тээвэрлэхдээ эрүүл ахуй, осол аюулгүйн шаардлагыг хангасан арга технологи, багаж хэрэгсэл, байр сав, тохиромжтой цаг хугацаа, зориулалтын тоноглогсон тээврийн хэрэгсэл ашиглаж, мэргэшсэн хүмүүсийг ажиллуулна.

²⁵ Идлэг шонхор экспортлогч нь идлэг шонхор барих, худалдан авах, хилээр нэвтрүүлэх талаар БОАЖЯ-тай гэрээ байгуулна.

²⁷ Ажлын хэсэг нь идлэг шонхор амьдаар нь барих, тээвэрлэх, арчлах, экспортод гаргах үйл ажиллагааны ажлын явцад хяналт тавих, хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангуулах, Байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад дэмжлэг үзүүлнэ.

Улсын нэр	CITES-ийн гэрчилгээний дугаар	Идлэг шонхор шувуу		
		эр	эм	бүгд
АНЭУ	557,563	5	5	10
Катар	564	5	5	10
Кувейт	567,569,574	9	11	20
Дүн	-	19	21	40

Мөн дээрх журмын 8 дугаар зүйлийн 8.13-т “экспортод гаргах идлэг шонхор шувууны хүйсийн харьцаа 1:1 байна” гэж заасан байхад 2014 онд гадаад оронд гаргасан шувуудын хувьд хүйсийн харьцаа эр 19 толгой, эм 21 толгой байгаа нь эм шувуудын тоо толгой эрээс 10.0 хувиар илүү байна.

Дээрх мэдээлэлтэй холбоотой 2013 оны баримт материал БОАЖЯ-ны архивт байхгүй байна.

Идлэг шонхор шувуу гадаад оронд гаргах зөвшөөрлийг Удирдан зохицуулах зөвлөлөөс “Ховор амьтан, ургамал, тэдгээрийн гаралтай эд зүйлийн гадаад худалдааг зохицуулах тухай” хуульд заасны дагуу олгож байгаа бөгөөд хуулийн холбогдох заалт дараах байдлаар зөрчигдсөн байна. Тухайлбал:

- Хуулийн 4 дүгээр зүйлийн 4.2²⁸-т заасны дагуу Удирдан зохицуулах болон Шинжлэх ухааны зөвлөлийн ажиллах журам, 8 дугаар зүйлийн 8.3-т заасны дагуу экспортлох зөвшөөрөл, гэрчилгээ олгох журмыг тус тус батлаагүй;
- Хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1-д Удирдан зохицуулах зөвлөлөөс экспортын гэрчилгээ, зөвшөөрөл олгохдоо:
 - амьтан, ургамал, тэдгээрийн гаралтай эд зүйлийг экспортлоход тухайн амьтан, ургамал оршин тогтноход хор хохирол учрах эсэх талаарх дүгнэлт, тодорхойлолт;
 - тухайн амьтан, ургамал, тэдгээрийн гаралтай эд зүйлийг хууль тогтоомжид заасны дагуу олж авсан тухай нутгийн захиргааны холбогдох байгууллага, албан тушаалтны тодорхойлолт;
 - амьтан, ургамлын тээвэрлэлт нь зохих журмын дагуу хийгдсэн болон шаардагдах нөхцөлийг бүрдүүлсэн эсэх талаарх нотолгоо;
 - тухайн амьтан, ургамлыг ашигласны төлбөр, хураамж тушаасан баримт бичиг зэргийг харгалзан үзэх ёстой боловч дээрх шаардлагыг тус тус хангаагүй байхад зөвшөөрөл олгосон байна.

Удирдан зохицуулах зөвлөл идлэг шонхор шувуу барьсан орон нутгийн тодорхойлолт, төлбөр, хураамж тушаасан баримт бичгийг харгалзахгүйгээр гадаад оронд гаргах зөвшөөрлийг олгосон нь байгалийн нөөц ашигласны төлбөр төлөхгүй байх, нутгийн захиргааны байгууллагын хяналтаас гаргах нөхцөлийг бүрдүүлсэн байна.

Аудитын явцад илрүүлсэн дээрх зөрчлөөс үзэхэд БОНХЯ (хуучнаар) Байгаль орчныг хамгаалах тухай хууль, Амьтны тухай хууль, Ховор амьтан, ургамал, тэдгээрийн гаралтай эд зүйлийн гадаад худалдааг зохицуулах тухай хуулиудад заасан чиг үүргээ бүрэн хэрэгжүүлээгүй, хуульд заасан журмуудыг батлаагүйгээс идлэг шонхор шувууг гадаад улсад гаргах үйл ажиллагааны хяналт суларч, хууль тогтоомж зөрчигдөх нөхцөлийг бүрдүүлсэн байна.

²⁸ Удирдан зохицуулах болон Шинжлэх ухааны зөвлөлийн бүрэлдэхүүнийг томилох, чөлөөлөх, зөвлөлийн ажиллах журмыг байгаль орчны асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батлана.

2.2. Идлэг шонхор шувуу барих үйл ажиллагаанд орон нутгийн захиргааны байгууллагаас тавих хяналт сул байна

Байгаль орчныг хамгаалах тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.2.1²⁹, 16.2.10³⁰, 17 дугаар зүйлийн 17.2.1³¹, 17.2.8³², Амьтны тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.5.1³³-д орон нутагт байгаль орчныг хамгаалах хууль тогтоомжийн биелэлтийг зохион байгуулах, байгалийн нөөцийг төрийн нэрийн өмнөөс хамгаалан, халдашгүй байдлыг хангах чиг үүргийг тухайн аймаг болон сумын Засаг дарга хэрэгжүүлэхээр хуульчилсан байна.

Мөн “Монгол Улсын нутаг дэвсгэр дээр идлэг шонхор амьдаар барих, тээвэрлэх, арчлах, экспортонд гаргах үйл ажиллагаанд мөрдөх журам”-д зааснаар идлэг шонхор шувуу барих үйл ажиллагаанд аймгийн БОГ(хуучнаар), байгаль орчны байцаагч, аймаг, сумын Засаг дарга нар тус тус хяналт тавих чиг үүрэгтэй, аймгийн Засаг дарга идлэг шонхор шувуу барих тусгай зөвшөөрлийг үндэслэн отгийн ахлагчтай гэрээ байгуулахаар журамласан байна.

Түүнчлэн сумын Засаг даргад гэрээг хэрэгжүүлэх талаар удирдамж, чиглэл өгөх, энэ үйл ажиллагааг аймгийн БОАЖГ, МХГ хяналтандаа байлгаж дэмжлэг үзүүлэх, Засаг даргаас хяналт тавих чиг үүргээ ажлын хэсэг байгуулан хэрэгжүүлэхээр заасан байна.

Гэвч идлэг шонхор шувуу барьсан Архангай, Баянхонгор, Дундговь, Завхан, Сүхбаатар, Өвөрхангай, Хэнтий аймгийн Засаг дарга нар 2013-2014 онуудад отогийн ахлагч нартай гэрээ байгуулаагүй, сумын Засаг даргад чиглэл, удирдамж хүргүүлээгүй, хяналт тавих ажлын хэсгийг байгуулаагүй нь дээрх журмын 2 дугаар зүйлийн 2.3³⁴, 3 дугаар зүйлийн 3.9³⁵, 7 дугаар зүйлийн 7.5³⁶-д заасныг зөрчсөн байна.

Дээрх журмын 3 дугаар зүйлийн 3.8³⁷-д заасны дагуу идлэг шонхор шувуу барих отог орон нутагт ажиллахаас өмнө тухайн аймгийн Засаг даргын тамгын газарт мэдэгдэж, отог ажиллуулах газрын зөвшөөрөл авах, аймгийн Засаг даргатай гэрээ байгуулах үүргээ биелүүлээгүй, БОНХЯ (хуучнаар) болон орон нутгийн захиргааны байгууллага хяналтыг хамтран хэрэгжүүлж ажиллаагүйгээс хяналтгүй үйл ажиллагаа явуулах нөхцөлийг бүрдүүлж, сумдын Засаг дарга нар дээрх журмын 7 дугаар зүйлийн 7.5³⁸, 8 дугаар зүйлийн 8.7³⁹ дахь заалтыг хэрэгжүүлээгүй байна.

“Монгол Улсын нутаг дэвсгэр дээр идлэг шонхор амьдаар барих, тээвэрлэх, арчлах, экспортонд гаргах үйл ажиллагаанд мөрдөх журам”-д идлэг шонхор шувуу барьсан протокол болон

²⁹ 16 дугаар зүйл. Аймаг, нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын болон Засаг даргын бүрэн эрх

2. Аймаг, нийслэлийн Засаг дарга байгаль орчныг хамгаалах, байгаль орчинд учруулсан хохирлыг нөхөн төлүүлэх талаар дараахь бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:

1/байгаль орчныг хамгаалах тухай хууль тогтоомж, Засгийн газрын шийдвэрийн биелэлтийг зохион байгуулах

³⁰ 10/байгалийн нөөцийг төрийн нэрийн өмнөөс хамгаалан, халдашгүй байдлыг нь хангах үүргийг тухайн нутаг дэвсгэртээ хариуцах.

³¹ 17 дугаар зүйл. Сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын болон Засаг даргын бүрэн эрх

2. Сум, дүүргийн Засаг дарга байгаль орчныг хамгаалах, байгаль орчинд учруулсан хохирлыг нөхөн төлүүлэх талаар дараахь бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:

1/нутаг дэвсгэртээ байгаль орчныг хамгаалах тухай хууль тогтоомж, иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, дээд шатны байгууллагын шийдвэрийн биелэлтийг зохион байгуулах

³² 8/байгалийн нөөцийг төрийн нэрийн өмнөөс хамгаалан, халдашгүй байдлыг нь хангах үүргийг тухайн нутаг дэвсгэртээ хариуцах;

³³ 5.5. Амьтныг хамгаалах, өсгөн үржүүлэх, зохистой ашиглах талаар аймаг, нийслэлийн Засаг дарга дараахь бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:

5.5.1. амьтныг хамгаалахтай холбогдсон хууль тогтоомж, түүний хэрэгжилттэй холбогдуулан гаргасан Засгийн газар, төрийн захиргааны төв байгууллагын шийдвэрийн биелэлтийг харьяалах нутаг дэвсгэртээ зохион байгуулах;

³⁴ Идлэг шонхорыг орон нутгаас бариулахад тухайн аймгийн Засаг дарга байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагаас худалдан авагч талд олгосон зөвшөөрлийг үндэслэн, идлэг шонхор барих отогийн ахлагчтай гэрээ байгуулна.

³⁵ Аймгийн Засаг дарга идлэг шонхор барих отогтой байгуулсан гэрээний заалтыг орон нутгийн түвшинд биелүүлэх, мөрдүүлэх талаар сумын Засаг даргад албан ёсоор мэдэгдэж, чиглэл удирдамж өгсөн байна. Энэ үйл ажиллагааг аймгийн Байгаль орчин, аялал жуулчлалын газар, мэргэжлийн хяналтын газар хяналтандаа байлгаж дэмжлэг үзүүлэн ажиллана.

³⁶ Идлэг шонхор орон нутгаасаа бариулж буй аймаг, сумд шат шатныхаа түвшинд идлэг шонхор амьдаар нь барих, тээвэрлэх, арчлах үйл ажиллагааг зохион байгуулах ажлын хэсгийг байгуулж ажиллуулна.

³⁷ Идлэг шонхор барих отог орон нутагт ажиллахаас өмнө тухайн аймгийн Засаг даргын тамгын газарт мэдэгдэж отог ажиллуулах газрын зөвшөөрөл авна. Урьдчилан газрын зөвшөөрөл аваагүй отгийг ажиллуулахыг хориглоно.

³⁸ Идлэг шонхор орон нутгаасаа бариулж буй аймаг, сумд шат шатныхаа түвшинд идлэг шонхор амьдаар нь барих, тээвэрлэх, арчлах үйл ажиллагааг зохион байгуулах ажлын хэсгийг байгуулж ажиллуулна.

³⁹ тухайн аймаг, сумын Засаг даргын тамгын газраас орон нутгийн төлөөлөгч 1 хүнийг томилон идлэг шонхор барих хугацаанд байнга ажиллуулна.

актыг үндсэн эхээр нь БОАЖЯ-д ирүүлэхээр журамласан байхад орон нутгаас акт, холбогдох материалыг ирүүлээгүй нь дээрх журмын 5.7⁴⁰-д заасныг зөрчсөн байна.

Сумдын Засаг дарга нарын хяналт хэрэгжүүлсэн байдлыг дурьдвал:

- Дундговь аймгийн Дэрэн сумын нутаг дэвсгэрээс 2 толгой идлэг шонхор барьсан зөрчил илэрсэн талаар сумын байгаль орчны байцаагч акт үйлдсэн гэх боловч, нотлох баримтгүй;
- Завхан аймгийн Түдэвтэй сумын Засаг дарга 2014 онд идлэг шонхор шувуу амьдаар нь барих, тээвэрлэх, арчлах, экспортлох үйл ажиллагааны явцад хяналт тавих, хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангуулах зорилгоор ажлын хэсэг байгуулсан боловч ажлын хэсэг хяналт тавьсан ажлын тайлан, акт үйлдээгүй.

Хууль хэрэгжүүлэхээр тодорхойлогдсон төрийн захиргааны холбогдох байгууллагууд үйл ажиллагаагаа уялдуулан хамтран ажиллаагүйгээс дээрх журмын 4.2⁴¹, 8.6⁴², 8.7⁴³ дахь заалтууд бүрэн хэрэгжээгүй байна.

Мөн аймгуудын БОГ (хуучнаар) болон МХГ-аас идлэг шонхор барих үйл ажиллагаанд хяналт тавьж байгаа гэх боловч үр дүн харилцан адилгүй, Байгаль орчныг хамгаалах тухай хуулийн 26 дугаар зүйлийн 26.1⁴⁴, 26.3⁴⁵ заалтын хэрэгжилт хангалтгүй байна.

Тухайлбал:

- Өвөрхангай аймгийн МХГ-аас Засгийн газрын тогтоолоор идлэг шонхор шувуу ашиг олох зорилгоор 5 жилээр хориглосон тул бүтээгдэхүүн нийлүүлэх нэгдсэн төлөвлөгөөнд төлөвлөгөөт болон урьдчилан сэргийлэх хяналт шалгалт хийхээр тусгаагүй;
- Хэнтий аймгийн БОГ-аас 2014 онд идлэг шонхор шувуу соёлын зориулалтаар барих ажилд хяналт тавьж, 14 хоног тутамд ажлын тайлан ирүүлэх тухай албан тоотыг сумдын Засаг дарга нарт хүргүүлсэн боловч сумдаас тайлан ирүүлээгүй;
- Баянхонгор аймгийн МХГ идлэг шонхор шувуу барьсан талаар мэдээлэлгүй, сумдаас 2015 оноос тайлан авч эхэлсэн байна. Баянхонгор аймгийн Баянбулаг сумын байгаль орчны байцаагч 2014 онд Завхан аймгийн Шилүүстэй сумаас явж байсан 2 автомашинтай иргэдийг саатуулан 3 идлэг шонхор шувуу барьсан байсныг илрүүлсэн;
- Сүхбаатар аймгийн Уулбаян сумын нутаг дэвсгэрээс 2013 онд 3 идлэг шонхор шувуу барьсан отогт сумын байгаль орчны улсын байцаагч, аймгийн байгаль орчны мэргэжилтэнтэй хамтран хяналтыг зөвхөн 1 удаа хийсэн байна.

Идлэг шонхор шувуу барих отог орон нутагт ажиллахаас өмнө тухайн аймгийн Засаг даргын тамгын газарт мэдэгдэж, отог ажиллуулах газрын зөвшөөрөл авах, аймгийн Засаг даргатай гэрээ байгуулах үүргээ биелүүлээгүй, БОНХЯ(хуучнаар), орон нутгийн захиргааны байгууллагууд үйл ажиллагаагаа уялдуулан хамтран ажиллаагүйгээс идлэг шонхор барих үйл ажиллагаанд тавих орон нутгийн хяналт бүрэн хэрэгжихгүй байна.

⁴⁰ Идлэг шонхор шувуу барьсан протокол болон актыг 2 хувь үйлдэж, үндсэн эхээр нь Байгаль орчин, аялал жуулчлалын яаманд ирүүлсэн нөхцөлд тухайн сумын Засаг даргын тамгын газрын зохих дансанд идлэг шонхор шувуу барьсны хураамжийг шилжүүлнэ.

⁴¹ Протокол үйлдэлгүйгээр отгоо буулган явсан, байршил газраа цэвэрлээгүй, хүлээлгэж өгөөгүй, төлбөр тооцооны зөрчил гаргасан тохиолдолд тухайн отгийн үйл ажиллагааг зогсоож барьсан идлэг шонхорыг хилээр нэвтрүүлэх зөвшөөрөл олгохгүй байх арга хэмжээг Байгаль орчин, аялал жуулчлалын яам авна

⁴² "Барьсан идлэг шонхорыг буцаан тавихдаа "... биеийн аль нэг хэсэгт тэмдэглэх, өд далавч, бусад эрхтэнийг гэмтээхийг хориглоно". Гэмтээсэн тохиолдолд 8.10-д заасны дагуу нөхөн төлбөр төлнө.

⁴³ Гэрээлэгч идлэг шонхор барих отог бүрт ... тухайн аймаг, сумын Засаг даргын тамгын газраас орон нутгийн төлөөлөгч 1 хүнийг томилон идлэг шонхор барих хугацаанд байнга ажиллуулна.

⁴⁴ Байгаль орчныг хамгаалах, түүний баялгийг зохистой ашиглах, нөхөн сэргээхэд тавих хяналтыг мэргэжлийн хяналтын байгууллага хэрэгжүүлнэ.

⁴⁵ ... аймаг, нийслэлд улсын ахлагч байцаагч, сум дүүрэгт улсын ахлах байцаагч, улсын байцаагч болон байгаль хамгаалагч тус тус ажиллана.



**МОНГОЛ УЛСЫН
БАЙГАЛЬ ОРЧИН,
АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН ЯАМ**

15160 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг,
Нэгдсэн Үндэстний гудамж 5/2, Засгийн газрын II байр,
Утас: 26 19 66, Факс: (976-51) 26 61 71,
E-mail: contact@mne.gov.mn, http://www.mne.mn

2017.07.20 № 06/4376
танай _____-ны № _____-т

ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗРЫН
НИЙЦЛИЙН АУДИТЫН ГАЗРЫН
ЗАХИРАЛ БӨГӨӨД ТЭРГҮҮЛЭХ
АУДИТОР Б.АЛТАНЗУЛ ТАНАА

Тайланд санал хүргүүлэх тухай

"Идлэг шонхор шувуу барих гадаад оронд гаргах үйл ажиллагааг зохицуулж буй хууль тогтоомжийн хэрэгжилт"-д хийсэн нийцлийн аудитын тайлангийн төсөлтэй танилцлаа. Төрийн аудитын тухай хуулийн 19 дүгээр зүйлийн 19.3.1 дэх заалтын дагуу тайланд тус яамны саналыг хүргүүлж байна.

1. Бүлэг 1, Идлэг шонхор шувуу барих, гадаад оронд гаргах үйл ажиллагааг зохицуулж буй хууль тогтоомжийн хэрэгжилт хангалтгүй байна гэсэн бүлгийн 1.1. Идлэг шонхор шувууг зохистой ашиглах талаар гарсан Засгийн газрын 2013-2014 оны шийдвэр нь шувууны нөөц, нөхөн сэргэх чадварт сөргөөр нөлөөлөхөөргүй байгаа талаарх мэдээлэл /11 хуудас дээрээс 22-28 дугаар мөр/-д Төсвийн тухай хуулийн 23 дугаар зүйлийн 23.8, Байгалийн нөөц ашигласны төлбөрийн тухай хуулийн 23 дугаар зүйлийн 23.1-23.2-т заасны дагуу төлбөр, хураамжийг орон нутгийн төсөвт төлөхөөр заасан байна. Харин Байгалийн нөөц ашигласны төлбөрийн тухай хуулийн 23 дугаар зүйлийн 23.1-23.2-т зөвхөн байгалийн нөөц ашигсны төлбөрийг орон нутагт төлөхөөр заасан байгааг анхаарах. Мөн /11 хуудас дээрээс 29-33 хуудас/ Амьтны тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.Тусгай төлбөр төлсөн иргэнд энэ хуулийн 24.3.3-т заасан зориулалтаар агнуурын амьтан агнах, барих тусгай зөвшөөрлийг төрийн захиргааны төв байгууллага олгоно. гэж заасан бөгөөд 4.1.7."агнуурын амьтан" гэж арьс, үс, мах болон бусад түүхий эдийг нь ашиглахаар агнаж ирсэн уламжлалтай, агнуурын нөөцтэй амьтныг; гэж тодорхойлсон байна. Иймд идлэг шонхор шувуу нь Амьтны тухай хуулийн 4.1.7-д зааснаар агнуурын амьтанд хамаарахгүй тул 29.1 дэх хэсэгт заасныг баримтлахгүй болно.

2. Тайлангийн 12 дугаар хуудасанд /дээрээс 21-23 дүгээр мөр/ орон нутгийн төсөвт төвлөрсөн байгалийн нөөц ашигласны төлбөрийн орлогын хэсгээс улсын төсөвт татан төвлөрүүлж, идлэг шонхор хамгаалах арга хэмжээнд зарцуулах эрх зүйн орчин бүрдээгүй байгаа талаар дурдсан байна. Байгалийн нөөц ашигласны төлбөрийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.2, 18 дугаар зүйлийн 18.1 дэх хэсэг, "Журам шинэчлэн батлах тухай" Монгол Улсын Засгийн газрын 2014 оны 43 дугаар тогтоолоор батлагдсан Байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээнд зарцуулах төлбөрийн орлогын хэсгийг бүрдүүлэх, зарцуулах, тайлагнах журамаар амьтны нөөц ашигласны төлбөрийн 50-аас доошгүй хувийг тухайн амьтныг хамгаалах арга хэмжээнд зарцуулахаар заасан байдаг.

205.1.2

3. Амьтын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 24.1, 24.2-т "Анчны үнэмлэх олгох, хураах, хүчингүй болгох журам"-ыг Хууль зүй, байгаль орчны болон боловсролын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн хамтран батлахыг заасан байдаг. Энэ журам батлагдаагүй байгаа талаар тайлангийн 15 дугаар хуудас /дээрээс 19-21 дүгээр мөр/, 21 дүгээр хуудсны дүгнэлтийн 7 дахь заалтад тусгасан байна. Анчны үнэмлэх олгох, хураах, хүчингүй болгох журам нь идлэг шонхор шувууг барих, гадаад оронд гаргах үйл ажиллагааг зохицуулахгүй болно.

4. Идлэг шонхор шувууг барихад өгөөш байдлаар олгож байгаа тагтаа, ногтруу шувууны төлбөр хураамжийн зөвшөөрлийг орон нутгаас олгодог, төлбөр хураамжийг орон нутагт төлдөг.

Иймд дээрх саналын дагуу "Идлэг шонхор шувуу барих гадаад оронд гаргах үйл ажиллагааг зохицуулж буй хууль тогтоомжийн хэрэгжилт"-д хийсэн нийцлийн аудитын тайлангийн төсөлд шаардлагатай өөрчлөлт, хасалтийг хийнэ үү.

ХҮРЭЭЛЭН БҮЙ ОРЧИН БАЙГАЛИЙН
НӨӨЦИЙН УДИРДАЛЫН ГАЗРЫН
ДАРГА Г.НЯМДАВАА



**Байгаль орчны аялал жуулчлалын яамнаас ирүүлсэн
саналд өгөх тайлбар**

БОАЖЯ-аас 2017 оны 07 сарын 20-ны өдрийн 06/4376 тоот албан бичгээр 4 заалт бүхий тайлбар ирүүлснийг судлан үзлээ.

Тайлбар 1.

Эхний хэсэг дэх санал нь зарчмын зөрүүгүй тул засвар хийгээгүй болно.

Идлэг шонхор шувуу барих тоо хэмжээ тогтоох болон тусгай зориулалтаар барих зөвшөөрөл олгох, төлбөр, хураамж төлөх харилцааг зохицуулж буй Амьтны тухай хуулийн 26 дугаар зүйлийн 26.3, 24 дүгээр зүйлийн 24.3, 29 дүгээр зүйлийн 29.2 дахь заалтуудад “агнуурын амьтан” гэж заасан байх тул тайланд өөрчлөлт оруулаагүй болно.

Тайлбар 2.

Саналыг хүлээн авч, тайланд найруулгын өөрчлөлт хийлээ.

Тайлбар 3. Саналын 3 дахь хэсгийг хүлээн авч холбогдох хэсгийг тайлангаас хасав.

Тайлбар 4.

Тайланд идлэг шонхор барихад ашиглах өгөөшийн төлбөр орон нутгийн төсөвт төвлөрөөгүй талаар тусгасан бөгөөд Байгаль орчныг хамгаалах тухай хуулийн 15 дугаар зүйлд заасны дагуу БОАЖЯ-аас өгөөшийн төлбөрийг бүрэн төвлөрүүлэх арга хэмжээ авах бүрэн эрхтэй байх тул тайланд засвар хийгээгүй болно.

Дүгнэлт

Аудитын явцад цуглуулсан нотлох зүйлс, аудитын дүнд үндэслэн дараах дүгнэлт хийж байна. Үүнд:

1. Монгол Улсын Засгийн газраас 2013 онд 20 хүртэл толгой, 2014 онд 40 хүртэл толгой идлэг шонхор шувуу тусгай зориулалтаар барихаар тогтоосон шийдвэр нь “Зэрлэг амьтан ба ургамлын ховордсон зүйлийг олон улсын хэмжээнд худалдаалах тухай конвенц”-ийн Байнгын хорооны зөвлөмж болон холбогдох хууль тогтоомжид нийцсэн байна.

2. Идлэг шонхор шувууг тусгай зориулалтаар барих тоо хэмжээ тогтоосон Засгийн газрын 2015-2016 оны тогтоолууд нууцын зэрэглэлтэй гарсан нь Байгаль орчныг хамгаалах тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.2.4-т Төр нь байгаль орчныг хамгаалах чиг үүргээ хэрэгжүүлэхдээ байгаль орчныг хамгаалах, байгалийн баялгийг ашиглах шийдвэр, үйл ажиллагаа ил тод байх зарчмыг баримтална гэж заасантай нийцэхгүй байна.

3. Ан агнуурын тухай хууль, Агнуурын нөөц ашигласны төлбөр, ан амьтан агнах, барих зөвшөөрлийн хураамжийн тухай хуулиуд 2012 онд Амьтны тухай хууль, Байгалийн нөөц ашигласны төлбөрийн тухай хуулиуд батлагдсанаар хүчингүй болсон байхад Засгийн газраас идлэг шонхор шувууны жишиг үнэ, төлбөр, хураамж, экологи-эдийн засгийн үнэлгээ тогтоосон Засгийн газрын 2009 оны 112, 2011 оны 23 дугаар тогтоолуудыг хуульд нийцүүлэн шинэчлэн батлаагүй нь Захиргааны ерөнхий хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.1-т заасан захиргааны хэм хэмжээний акт хуульд нийцсэн байх заалттай нийцэхгүй байна.

4. БОАЖ-ын сайдын 2012 оны А-299 дүгээр тушаалаар батлагдсан Монгол Улсын нутаг дэвсгэр дээр идлэг шонхор амьдаар барих, тээвэрлэх, арчлах, экспортонд гаргах үйл ажиллагаанд мөрдөх журмын 5.2, 5.3 дахь заалтууд нь Байгалийн нөөц ашигласны төлбөрийн тухай хуулийн 12.1.6, 17.1.6 дахь заалт, Засгийн газрын 2009 оны 112 дугаар тогтоолын 2 дахь заалтуудтай нийцээгүй, БОНХЯ(хуучнаар)-ны Хүрээлэн буй орчин, байгалийн нөөцийн удирдлагын газраас 1 толгой идлэг шонхорын төлбөрт 6.4 сая төгрөгийг төлүүлсэн, нутгийн захиргааны байгууллагаас хяналтыг бүрэн хэрэгжүүлээгүйгээс нийт 46 толгой идлэг шонхор шувууны төлбөр, хураамжийн зөрүүгээс 707.2 сая төгрөг орон нутгийн төсөвт дутуу төвлөрсөн байна.

5. Ховор амьтан, ургамал, тэдгээрийн гаралтай эд зүйлийн гадаад худалдааг зохицуулах тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.3-т заасны дагуу Байгаль орчны асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн идлэг шонхор шувууг гадаад улсад гаргах зөвшөөрөл, гэрчилгээ олгох журмыг батлаагүй, Удирдан зохицуулах зөвлөлөөс мөн хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1-д заасны дагуу орон нутгийн тодорхойлолт болон төлбөр төлсөн баримт зэргийг харгалзан үзэлгүйгээр гадаад улсад гаргах зөвшөөрөл олгосон, орон нутгийн захиргааны байгууллагаас Байгаль орчныг хамгаалах тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.2.1, 16.2.10, 17 дугаар зүйлийн 17.2.1, 17.2.8, 26 дугаар зүйлийн 26.1 дэх хэсгүүдэд заасан хяналтын чиг үүргээ бүрэн хэрэгжүүлээгүйгээс 2013-2014 онд 9 толгой идлэг шонхор шувууны төлбөр, хураамжийн 194.5 сая төгрөг орон нутгийн төсөвт төвлөрөөгүй.

6. Идлэг шонхор шувуу барихад ашиглаж буй өгөөшийн төлбөр, хураамжийн 11.5 сая төгрөгийг орон нутгийн төсөвт дутуу төвлөрүүлсэн нь Амьтны тухай хуулийн 32 дугаар зүйлийн 32.1, Засгийн газрын 2011 оны 65 тогтоолд ой хээрийн бусад агнуурын шувуу шувууны төлбөр хураамжид 12 ам.доллар төлнө гэж заасныг тус тус зөрчсөн.

7. Цахилгаан дамжуулах 15кВт-ын агаарын шугамын шонг идлэг шонхор шувуу суухад аюулгүй болгох талаар холбогдох арга хэмжээ авах шаардлагатай байна.

8. БОНХЯ (хуучнаар) Амьтны тухай хууль, Ховор амьтан, ургамал, тэдгээрийн гаралтай эд зүйлийн гадаад худалдааг зохицуулах тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.2, 8 дугаар зүйлийн 8.3-д заасан журмуудыг батлаагүй, орон нутгийн захиргааны байгууллагуудтай ажлын уялдаа холбоо хангалтгүй байсан нь идлэг шонхор барих, гадаад оронд гаргах үйл ажиллагаанд тавих хяналт суларч, хууль тогтоомж зөрчигдөх нөхцөлийг бүрдүүлсэн.

Зөвлөмж

Аудитын дүн, дүгнэлтэд үндэслэн дараах арга хэмжээг авч хэрэгжүүлэхийг дор дурьдсан байгууллага, албан тушаалтанд зөвлөж байна. Үүнд:

Монгол Улсын Засгийн газарт:

1. Идлэг шонхор шувууны жишиг үнэ, төлбөр, хураамж, экологи-эдийн засгийн үнэлгээг Амьтны тухай хууль, Байгалийн нөөц ашигласны төлбөрийн тухай хууль, Төлбөр тооцоог үндэсний мөнгөн тэмдэгтээр гүйцэтгэх тухай хуульд нийцүүлэн шинэчлэн батлах;

2. Цаашид идлэг шонхор шувууг тусгай зориулалтаар барих тоо хэмжээ тогтоох тухай Засгийн газрын шийдвэрийг Байгаль орчныг хамгаалах тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.2.4 дэх заалтад нийцүүлэн ил тод гаргаж байх.

Байгаль орчин, аялал жуулчлалын сайдад:

1. БОАЖ-ын сайдын 2012 оны А-299 дүгээр тушаалаар батлагдсан “Монгол Улсын нутаг дэвсгэр дээр идлэг шонхор амьдаар барих, тээвэрлэх, арчлах, экспортонд гаргах үйл ажиллагаанд мөрдөх журам”-ыг Байгаль орчныг хамгаалах тухай хууль, Төсвийн тухай хууль, Амьтны тухай хууль болон Байгалийн нөөц ашигласны төлбөрийн тухай хуульд нийцүүлэн шинэчилэн батлаж, идлэг шонхор шувуу болон өгөөшийн байгалийн нөөц ашигласны төлбөр, хураамжийг бүрэн төвлөрүүлэх арга хэмжээ авч, хэрэгжүүлэх;

2. Ховор амьтан, ургамал, тэдгээрийн гаралтай эд зүйлийн гадаад худалдааг зохицуулах тухай хуулийн дагуу Удирдан зохицуулах зөвлөл болон шинжлэх ухааны зөвлөлийн ажиллах журам болон Удирдан зохицуулах зөвлөлөөс зөвшөөрөл, гэрчилгээ олгох журмыг тус тус батлаж, идлэг шонхор шувууг гадаад улсад гаргах зөвшөөрөл олгох, олгохоос татгалзах хуулийн заалтыг бүрэн хэрэгжүүлж ажиллах;

3. Цахилгаан дамжуулах 15кВт-ын агаарын шугамын шонг идлэг шонхор шувуу суухад аюулгүй болгох талаар холбогдох арга хэмжээ авах;

4. Идлэг шонхор шувуу барих, гадаадад гаргах үйл ажиллагаатай холбоотой чиг үүргээ бүрэн хэрэгжүүлж, орон нутгийн захиргааны байгууллагуудтай үйл ажиллагаагаа уялдуулан хамтран ажиллах;

5. Амьтны мэдээллийн санг зохих журмын дагуу бүрдүүлэх.

Архангай, Баянхонгор, Дундговь, Завхан, Өвөрхангай, Сүхбаатар, Хэнтий аймгийн Засаг дарга нарт:

1. Сумын Засаг дарга нар, БОГ, МХГ-уудтай ажлын уялдаа холбоо болон идлэг шонхор шувуу болон өгөөш болгон ашиглаж буй тагтаа, ногтруу барих үйл ажиллагаанд тавих хяналтыг сайжруулах.

Хавсралт

Идлэг шонхор шувуу барих, гадаад улсад гаргах үйл ажиллагааг зохицуулж буй хууль тогтоомжийн хэрэгжилтэд хийсэн нийцлийн аудитаар илэрсэн зөрчлийн жагсаалт

№	Хууль тогтоомжийн нэр	Заалт	Илэрсэн зөрчил	Зөрчил гаргасан байгууллага, албан тушаалтан
1	Төсвийн тухай хууль	23.8.Сум, дүүргийн төсвийн татварын орлого дараах орлогоос бүрдэнэ: 23.8.4.агнуурын нөөц ашигласны төлбөр, ан амьтан агнах, барих зөвшөөрлийн хураамж;	БОАЖС-ын 2012 оны А-299 дугаар тушаалаар батлагдсан “Монгол Улсын нутаг дэвсгэр дээр идлэг шонхор амьдаар барих, тээвэрлэх, арчлах, экспортонд гаргах үйл ажиллагаанд мөрдөх журам”-ын 5.6-д төлбөр, хураамжийг БОАЖА-ны холбогдох дансанд төвлөрүүлэхээр журамласан.	БОАЖ/БОНХАЖА/-ын сайд
2		35 дугаар зүйл.Мэдээллийн сангийн бүрдэл 1.Улсын мэдээллийн сан дараахь зүйлийн талаархи мэдээллээс бүрдэнэ: 6/амьтан;	БОАЖА амьтны мэдээллийн сан дахь идлэг шонхор шувууны мэдээллийг бүрдүүлээгүй.	БОАЖА/БОНХАЖА/
3		15 дугаар зүйл.Төрийн захиргааны төв байгууллагын бүрэн эрх 15/байгаль орчны мэдээллийн сангийн үйл ажиллагааны талаархи хууль тогтоомжийг хэрэгжүүлэх ажлыг нэгдсэн удирдлагаар хангаж, хэрэгжилтэд нь хяналт тавих; 38 дугаар зүйл.Мэдээллийн сангийн үйл ажиллагааг хангах байгууллага 1.Байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага мэдээллийн сангийн үйл ажиллагааг улсын хэмжээнд удирдан зохион байгуулна.	БОАЖА байгаль орчны мэдээллийн сангийн үйл ажиллагааны талаархи хууль тогтоомжийг хэрэгжүүлэх ажлыг нэгдсэн удирдлагаар хангаж, хэрэгжилтэд нь хяналт тавих, улсын хэмжээнд удирдан зохион байгуулах чиг үүргээ хэрэгжүүлээгүй.	БОАЖА/БОНХАЖА/
4	Байгаль орчныг хамгаалах тухай хууль	16 дугаар зүйл.Аймаг, нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын болон Засаг даргын бүрэн эрх 2.Аймаг, нийслэлийн Засаг дарга байгаль орчныг хамгаалах, байгаль орчинд учруулсан хохирлыг нөхөн төлүүлэх талаар дараахь бүрэн эрхийг хэрэгжүүлнэ: 2.Аймаг, нийслэлийн Засаг дарга байгаль орчныг хамгаалах, байгаль орчинд учруулсан хохирлыг нөхөн төлүүлэх талаар дараахь бүрэн эрхийг хэрэгжүүлнэ: 10/байгалийн нөөцийг төрийн нэрийн өмнөөс хамгаалан, халдашгүй байдлыг нь хангах үүргийг тухайн нутаг дэвсгэртээ хариуцах.	Архангай, Баянхонгор, Дундговь, Завхан, Сүхбаатар, Өвөрхангай, Хэнтий аймгийн засаг дарга нар идлэг шонхор шувууг төрийн нэрийн өмнөөс хамгаалан, халдашгүй байдлыг хангах үүргийг тухайн нутаг дэвсгэртээ хариуцах чиг үүргээ бүрэн хэрэгжүүлээгүй.	Архангай, Баянхонгор, Дундговь, Завхан, Сүхбаатар, Өвөрхангай, Хэнтий аймгийн Засаг дарга
5		26 дугаар зүйл.Байгаль орчны хяналт 1.Байгаль орчныг хамгаалах, түүний баялгийг зохистой ашиглах, нөхөн	Орон нутаг дахь БОГ (хуучнаар) болон МХГ-аас энэ талаар мэдээлэлгүй, хяналт шалгалт хийгээгүй.	Архангай, Баянхонгор, Дундговь, Завхан, Сүхбаатар,

		сэргээхэд тавих хяналтыг мэргэжлийн хяналтын байгууллага хэрэгжүүлнэ. 3.Мэргэжлийн хяналтыг хэрэгжүүлэх төв байгууллагад улсын ерөнхий байцаагч, салбарын улсын ерөнхий байцаагч, улсын ахлах байцаагч, аймаг нийслэлд улсын ахлах байцаагч, улсын байцаагч, сум дүүрэгт улсын ахлах байцаагч, улсын байцаагч /цаашид "улсын байцаагч" гэх/ болон байгаль хамгаалагч тус тус ажиллана.		Өвөрхангай, Хэнтий аймгийн мэргэжлийн хяналтын газар
6		32 дугаар зүйл.Амьтан ашигласны төлбөр, агнуурын амьтан агнах, барих төлбөр, хураамж 32.1.Иргэн, хуулийн этгээд амьтан ашиглах, агнуурын амьтан агнах, барихад төлбөр, хураамж төлнө.	Идлэг шонхор шувуу барихад ашиглах өгөөшийн байгалийн нөөц ашигласны төлбөрийн 11.5 сая төгрөг дутуу төвлөрсөн.	БОАЖЯ, Аймгийн Засаг дарга болон МХГ, БОГ, сумын байгаль орчны байцаагч
7		29 дүгээр зүйл.Тусгай зориулалтаар агнуурын амьтан агнах, барих 29.1.Тусгай төлбөр төлсөн иргэнд энэ хуулийн 24.3.3-т заасан зориулалтаар агнуурын амьтан агнах, барих тусгай зөвшөөрлийг төрийн захиргааны төв байгууллага олгоно.	БОНХЯ-ны Хүрээлэн буй орчин байгалийн нөөцийн газраас тусгай зөвшөөрлийг төлбөр төлөөгүй байхад олгосон.	БОАЖЯ-ны Хүрээлэн буй орчин, байгалийн нөөцийн удирдлагын газар
8	Амьтны тухай хууль	34 дүгээр зүйл.Амьтны жам ёсны эрхийг хүндэтгэж, энэрэнгүй хандах 34.1.Амьтныг өмчлөх, эзэмших, ашиглах, агнуур хийх үйл ажиллагааг явуулахдаа амьтны жам ёсны эрхийг хүндэтгэн энэрэнгүй ёсоор хандана. 34.2.Амьтныг агнах, барих, тавих, арчилж тордох, ачиж тээвэрлэхдээ эрүүл ахуй, осол аюулгүйн шаардлагыг хангасан арга технологи, багаж хэрэгсэл, байр сав, тохиромжтой цаг хугацаа, зориулалтын тоноглогсон тээврийн хэрэгсэл ашиглаж, мэргэшсэн хүмүүсийг ажиллуулна.	Идлэг шонхор шувуу агнах, барих, тавих, арчилж тордох, ачиж тээвэрлэхдээ эрүүл ахуй, осол аюулгүйн шаардлагыг хангасан арга технологи, багаж хэрэгсэл, байр сав, тохиромжтой цаг хугацаа, зориулалтын тоноглогсон тээврийн хэрэгсэл ашиглаж, мэргэшсэн хүмүүсийг ажиллуулах, агнуур хийх үйл ажиллагааг явуулахдаа амьтны жам ёсны эрхийг хүндэтгэн энэрэнгүй ёсоор хандах асуудлыг холбогдох журмаар нарийвчлан зохицуулаагүй байна.	БОАЖЯ/БОНХАЖЯ/-ны сайд
9	Байгалийн нөөц ашигласны төлбөрийн тухай хууль	12 дугаар зүйл.Ан амьтны нөөц ашигласны төлбөр тооцох үзүүлэлт 12.1.Ан амьтны нөөц ашигласны төлбөрийг дараах үзүүлэлтээр тооцно: 12 дугаар зүйлийн 12.1.6.гадаадын иргэнд агнуулсан болон гадаад улсад амьдаар нь аливаа зориулалтаар гаргасан ан амьтны төлбөрийг тухайн ан олзворын гадаад зах зээлийн тухайн үеийн үнэ буюу эрх бүхий байгууллагаас тогтоосон жишиг үнээр. 17 дугаар зүйл.Ан амьтны нөөц ашигласны төлбөрийн хувь, хэмжээ 17.1.6.амьдаар нь гадаад оронд гаргасан ан амьтны төлбөрийг гадаад зах зээлийн тухайн үеийн үнэ буюу эрх	БОАЖ-ын сайдын 2012 оны А-299 дүгээр тушаалаар баталсан "Монгол Улсын нутаг дэвсгэр дээр идлэг шонхор амьдаар барих, тээвэрлэх, арчлах, экспортонд гаргах үйл ажиллагаанд мөрдөх журам"-ын 12.1.6, 17.1.6 дахь заалтууд хуулийн заалттай зөрчилтэй. БОНХЯ(хуучнаар)-ны Хүрээлэн буй орчин, байгалийн нөөцийн газар (хуучнаар) хуулийн заалтыг буруу хэрэглэж идлэг шонхор шувууны байгалийн нөөц ашигласны төлбөрийг дутуу төвлөрүүлсэн.	БОАЖЯ/БОНХАЖЯ/-ны сайд

		бүхий байгууллагаас тогтоосон жишиг үнийн 80-90 хувиар.		
10		23 дугаар зүйл.Байгалийн нөөц ашигласны төлбөр төлөх 23.1.Сум, дүүргийн Засаг дарга байгалийн нөөц ашигласны төлбөр хураах эрх бүхий албан тушаалтныг томилон ажиллуулна. 23.2.Байгалийн нөөц ашигласны төлбөрийн орлогыг дараа сарын 10-ны өдрийн дотор орон нутгийн төсөвт төлж, төлбөрийн жилийн тайланг дараа оны 01 дүгээр сарын 10-ны өдрийн дотор харьяалагдах татварын албанд тушааж эцсийн тооцоо хийнэ.	БОАЖС-ын 2012 оны А-299 дугаар тушаалаар батлагдсан “Монгол Улсын нутаг дэвсгэр дээр идлэг шонхор амьдаар барих, тээвэрлэх, арчлах, экспортонд гаргах үйл ажиллагаанд мөрдөх журам”-ын 5.6-д төлбөр, хураамжийг БОАЖА-ны холбогдох дансанд төвлөрүүлэхээр журамласан.	БОАЖА/БОНХАЖА/-ны сайд
11		4 дүгээр зүйл.Конвенцийг хэрэгжүүлэх байгууллага 4.2.Удирдан зохицуулах болон Шинжлэх ухааны зөвлөлийн бүрэлдэхүүнийг томилох, чөлөөлөх, зөвлөлийн ажиллах журмыг байгаль орчны асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална.	Удирдан зохицуулах болон Шинжлэх ухааны зөвлөлийн ажиллах журмыг батлаагүй.	БОАЖА/БОНХАЖА/-ны сайд
12		8 дугаар зүйл. Зөвшөөрөл, гэрчилгээ 8.3.Зөвшөөрөл, гэрчилгээ олгох журам болон загварыг байгаль орчны асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална.	Идлэг шонхор шувууг экспортлох зөвшөөрөл, гэрчилгээ олгох журмыг батлаагүй.	БОАЖА/БОНХАЖА/-ны сайд
13	Ховордсон амьтан, ургамал, тэдгээрийн гаралтай эд зүйлийн гадаад худалдааг зохицуулах тухай хууль	9 дүгээр зүйл. Зөвшөөрөл, гэрчилгээ олгох, олгохоос татгалзах 9.1.Удирдан зохицуулах зөвлөл нь дараахь нөхцөлийг харгалзан зөвшөөрөл, гэрчилгээ олгоно: 9.1.1.энэ хуулийн 6.1.1, 6.1.2, 6.1.3-т заасан дүгнэлт, тодорхойлолтыг авсан эсэх; 9.1.2. Конвенцийн 1, 2 дугаар хавсралтад орсон амьтан, ургамал, тэдгээрийн гаралтай эд зүйлийг экспортлох зөвшөөрөл олгохдоо шаардлагатай гэж үзвэл энэ хуулийн 6.1.4-т заасан дүгнэлт авсан эсэх; 9.1.3. тухайн амьтан, ургамал, тэдгээрийн гаралтай эд зүйлийг хууль тогтоомжид заасны дагуу олж авсан тухай нутгийн захиргааны холбогдох байгууллага, албан тушаалтны тодорхойлолт; 9.1.5. амьтан, ургамлын тээвэрлэлт нь зохих журмын дагуу хийгдсэн болон шаардагдах нөхцөлийг бүрдүүлсэн эсэх; 9.1.7. тухайн амьтан, ургамал, тэдгээрийн гаралтай эд зүйлийг олж авахдаа Агнуурын нөөц ашигласны төлбөр, ан амьтан барих зөвшөөрлийн хураамжийн тухай, Байгалийн ургамал ашигласны	Хуульд заасан шаардлагыг хангаагүй байхад идлэг шонхор шувууг экспортлох зөвшөөрөл олгосон.	Удирдан зохицуулах зөвлөл

		төлбөрийн тухай хуульд заасан төлбөр, хураамж тушаасан баримт бичиг.		
14	Төлбөр тооцоог үндэсний мөнгөн тэмдэгтээр гүйцэтгэх тухай хууль	4 дүгээр зүйл.Үндэсний мөнгөн тэмдэгтийн хэрэглээ 4.3.Монгол Улсын хууль тогтоомжид хураамж, шимтгэл, хариуцлагын хэмжээг тодорхойлохдоо зөвхөн төгрөгөөр илэрхийлнэ.	Монгол Улсын Засгийн газрын 2009 оны 112 дугаар тогтоолын 2 дугаар зүйлд амьдаар барих идлэг шонхор шувууны хураамжийг ам.доллараар тогтоосныг шинэчлэн батлаагүй.	МУЗГ
15	Захиргааны ерөнхий хууль	60 дугаар зүйл.Захиргааны хэм хэмжээний актад тавих шаардлага 60.1.Захиргааны хэм хэмжээний акт дараах шаардлагыг хангасан байна: 60.1.1.Монгол Улсын Үндсэн хууль, энэ хууль болон бусад хуульд нийцсэн байх;	Идлэг шонхор шувууны жишиг үнэ, төлбөр, хураамж, экологи-эдийн засгийн үнэлгээ тогтоосон МУЗГ-ын 2009 оны 112, 2011 оны 23 дугаар тогтоолуудыг шинэчлэн батлаагүй.	МУЗГ
16		2 дугаар зүйлийн 2.1. Идлэг шонхор экспортлогч /цаашид худалдан авагч тал гэх/ нь идлэг шонхор барих, худалдан авах, хилээр нэвтрүүлэх талаар Байгаль орчин, аялал жуулчлалын яамтай гэрээ байгуулна.	2013 онд Кувейт улсын эрхэмсэг Эмир Монгол Улсад айлчилж байгаатай холбогдуулан Гадаад Харилцааны сайдаас гаргасан хүсэлтийг харгалзан, 2014 онд Монгол Улсын Засгийн газраас АНЭУ-ын дэд ерөнхийлөгч, Ерөнхий сайд бөгөөд Дубай хотын захирагчид илгээсэн идлэг шонхор шувуу бэлэглэх тухай албан бичгийг үндэслэн гэрээ байгуулахгүйгээр тусгай зөвшөөрөл олгосон.	БОАЖЯ-ны Хүрээлэн буй орчин, байгалийн нөөцийн удирдлагын газар
17	БОАЖС-ын 2012 оны А-299 дугаар тушаалаар батлагдсан “Монгол Улсын нутаг дэвсгэр дээр идлэг шонхор амьдаар барих, тээвэрлэх, арчлах, экспортонд гаргах үйл ажиллагаанд мөрдөх журам”	2 дугаар зүйлийн 2.3. Идлэг шонхорыг орон нутгаас бариулахад тухайн аймгийн Засаг дарга байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагаас худалдан авагч талд олгосон зөвшөөрлийг үндэслэн, идлэг шонхор барих отогийн ахлагчтай гэрээ байгуулна.	Архангай, Баянхонгор, Дундговь, Завхан, Сүхбаатар, Өвөрхангай, Хэнтий аймгийн Засаг дарга нар 2013-2014 онуудад отогийн ахлагч нартай гэрээ байгуулаагүй.	Архангай, Баянхонгор, Дундговь, Завхан, Сүхбаатар, Өвөрхангай, Хэнтий аймгийн Засаг дарга
18		3 дугаар зүйлийн 3.9. Аймгийн Засаг дарга идлэг шонхор барих отогтой байгуулсан гэрээний заалтыг орон нутгийн түвшинд биелүүлэх, мөрдүүлэх талаар сумын Засаг даргад албан ёсоор мэдэгдэж, чиглэл удирдамж өгсөн байна. Энэ үйл ажиллагааг аймгийн Байгаль орчин, аялал жуулчлалын газар, мэргэжлийн хяналтын газар хяналтандаа байлгаж дэмжлэг үзүүлэн ажиллана.	Аймгийн Засаг дарга идлэг шонхор барих сумын Засаг даргад чиглэл, удирдамж хүргүүлээгүй.	
19		4 дүгээр зүйлийн 4.2. Протокол үйлдэлгүйгээр отгоо буулган явсан, байршил газраа цэвэрлээгүй, хүлээлгэж өгөөгүй, төлбөр тооцооны зөрчил гаргасан тохиолдолд тухайн отгийн үйл ажиллагааг зогсоож барьсан идлэг шонхорыг хилээр нэвтрүүлэх зөвшөөрөл олгохгүй байх арга хэмжээг Байгаль орчин, аялал жуулчлалын яам авна	Журмын заалт хэрэгжээгүй.	БОАЖЯ /БОНХАЖЯ/

20		5 дугаар зүйлийн 5.7. Идлэг шонхор шувуу барьсан протокол болон актыг 2 хувь үйлдэж, үндсэн эхээр нь Байгаль орчин, аялал жуулчлалын яаманд ирүүлсэн нөхцөлд тухайн сумын Засаг даргын тамгын газрын зохих дансанд идлэг шонхор шувуу барьсны хураамжийг шилжүүлнэ.	Идлэг шонхор шувуу барьсан сумын Засаг даргын тамгын газраас протокол болон актыг 2 хувь үйлдэж, үндсэн эхээр нь Байгаль орчин, аялал жуулчлалын яаманд ирүүлээгүй.	Архангай, Баянхонгор, Дундговь, Завхан, Сүхбаатар, Өвөрхангай, Хэнтий аймгуудын нэр бүхий сумдын Засаг дарга
21		7 дугаар зүйлийн 7.1. Идлэг шонхор амьдаар нь барих, тээвэрлэх, арчлах, экспортод гаргах үйл ажиллагааг зохион байгуулах ажлын хэсгийг Байгаль орчин аялал, жуулчлалын сайдын тушаалаар байгуулна.	БОАЖ-ын сайдын тушаалаар идлэг шонхор амьдаар нь барих, тээвэрлэх, арчлах, экспортод гаргах үйл ажиллагааг зохион байгуулах ажлын хэсгийг байгуулаагүй.	БОАЖЯ /БОНХАЖЯ/-ны сайд
22		7 дугаар зүйлийн 7.5. Идлэг шонхор орон нутгаасаа бариулж буй аймаг, сумд шат шатныхаа түвшинд идлэг шонхор амьдаар нь барих, тээвэрлэх, арчлах үйл ажиллагааг зохион байгуулах ажлын хэсгийг байгуулж ажиллуулна.	Аймгийн Засаг дарга идлэг шонхор барих үйл ажиллагаанд хяналт тавих ажлын хэсгийг байгуулаагүй.	Архангай, Баянхонгор, Дундговь, Завхан, Сүхбаатар, Өвөрхангай, Хэнтий аймгийн Засаг дарга
23		8 дугаар зүйлийн 8.1. Идлэг шонхор шувуу барих авто тээврийн хэрэгслийн тоо нь гэрээлэгч тус бүрийн 10 шонхор тутамд 5-аас илүүгүй байна.	Барьсан 10 толгой идлэг шонхор тутамд хамгийн багадаа 14 гадаадын иргэн, 17 автомашин явсан.	БОАЖЯ-ны Хүрээлэн буй орчин, байгалийн нөөцийн удирдлагын газар
24		8 дугаар зүйлийн 8.6. "Барьсан идлэг шонхорыг буцаан тавихдаа "... биеийн аль нэг хэсэгт тэмдэглэх,өд далавч, бусад эрхтэнийг гэмтээхийг хориглоно". Гэмтээсэн тохиолдолд 8.10-д заасны дагуу нөхөн төлбөр төлнө	Журмын заалтыг хэрэгжүүлэх хяналт тавигдаагүй.	Архангай, Баянхонгор, Дундговь, Завхан, Сүхбаатар, Өвөрхангай, Хэнтий аймгийн нэр бүхий сумдын Засаг дарга
25		8 дугаар зүйлийн 8.7. Гэрээлэгч идлэг шонхор барих отог бүрт ... тухайн аймаг, сумын Засаг даргын тамгын газраас орон нутгийн төлөөлөгч 1 хүнийг томилон идлэг шонхор барих хугацаанд байнга ажиллуулна.	Тухайн аймаг, сумын Засаг даргын тамгын газраас орон нутгийн төлөөлөгч 1 хүнийг томилон идлэг шонхор барих хугацаанд байнга ажиллуулаагүй.	Архангай, Баянхонгор, Дундговь, Завхан, Сүхбаатар, Өвөрхангай, Хэнтий аймгийн нэр бүхий сумдын Засаг дарга
26		8 дугаар зүйлийн 8.13. Экспортод гаргах идлэг шонхорын хүйсийн харьцаа 1:1 байна.	2014 онд гадаад оронд гаргасан шувуудын хувьд хүйсийн харьцаа эр 19 толгой, эм 21 толгой байгаа нь эм шувуудын тоо толгой эрээс 10.0 хувиар илүү байна.	БОАЖЯ-ны Хүрээлэн буй орчин, байгалийн нөөцийн удирдлагын газар
27	Засгийн газрын 2010 оны 119 дүгээр тогтоолоор батлагдсан Захиргааны хэм хэмжээ тогтоосон шийдвэр гаргах журам /ЗГ-ын 2016-9-14-ний өдрийн 86-р тогтоолоор хүчингүй болсонд тооцсон/	2.1. Хуулиар тусгайлан эрх олгогдсон эрх бүхий этгээд дараахь тохиолдолд нэн даруй шийдвэр гаргана: 2.1.1. тухайн харилцааг зохицуулах хууль шинээр батлагдан гарсан, хуульд нэмэлт, өөрчлөлт оруулсан, хууль хүчингүй болсон.	Идлэг шонхор шувууны жишиг үнэ, төлбөр, хураамж, экологи-эдийн засгийн үнэлгээ тогтоосон МУЗГ-ын 2009 оны 112, 2011 оны 23 дугаар тогтоолуудыг шинэчлэн батлаагүй.	МУЗГ
Нийт дүн		7 хуулийн 17 заалт, 2 журмын 12 заалт зөрчигдсөн.		



МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙ АУДИТОРЫН
ТУШААЛ

2017 оны 10 сарын 09 өдөр

Дугаар А/130

Улаанбаатар хот

Г Аудитын тайлан баталгаажуулах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.4.7 дахь заалт, Монгол Улсын Ерөнхий аудиторын 2016 оны А/146 дугаар тушаалаар батлагдсан Нийцлийн аудитын түр журмын 9.2 дахь заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. "Идлэг шонхор барих, гадаад оронд гаргах үйл ажиллагааг зохицуулж буй хууль тогтоомжийн хэрэгжилт"-д хийсэн нийцлийн аудитын тайланг нэгдүгээр, тус аудитаар өгсөн албан шаардлагын жагсаалтыг хоёрдугаар хавсралтаар тус тус баталсугай.

2. Аудитын тайланг Засгийн газар, Байгаль орчин, аялал жуулчлалын яам, Архангай, Баянхонгор, Дундговь, Завхан, Өвөрхангай, Сүхбаатар, Хэнтий аймгийн Засаг дарга нар, "Монголын мэргэжлийн анчдын холбоо" ТББ-т тус тус хүргүүлсүгэй.

3. Аудитын тайланд дурдагдсан зөрчлүүдийг арилгаж, өгсөн зөвлөмж, албан шаардлагыг хэрэгжүүлэх арга хэмжээ авч, үр дүнг 2017 оны 12 дугаар сарын 01-ний өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэхийг Байгаль орчин, аялал жуулчлалын сайдад зөвлөсүгэй.

4. Аудитаар өгсөн зөвлөмжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Нийцлийн аудитын газрын захирал бөгөөд тэргүүлэх аудиторт, энэхүү тушаал гарснаас хойш 14 хоногийн дотор аудитын тайлан, ажлын баримт, нотлох зүйлийг зохих журам, зааврын дагуу архивын нэгж болгон байгууллагын архивт хүлээлгэн өгөхийг хариуцсан аудиторуудад тус тус үүрэг болгосугай.

МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙ АУДИТОР



Д.ХҮРЭЛБААТАР

Монгол Улсын Ерөнхий аудиторын
2017 оны 10 дугаар сарын 09-ны өдрийн
4/180 тушаалын хоёрдугаар хавсралт



Аудитаар илэрсэн зөрчлийн жагсаалт

/сая төг/

№	Хариуцагч	Албан шаардлагын товч утга	Дугаар	Дүн
1	БОАЖЯ-ны Хүрээлэн буй орчин, байгалийн нөөцийн удирдлагын газрын дарга Г.Нямдаваа	Зөрчил арилгуулах тухай	ҮАГ-НАГ/2017/09-НА	913.2